

Агуулга

Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал3

I. Нийгмийн үзүүлэлт6

1. Хүн ам6
2. Хөдөлмөр9
3. Нийгмийн даатгал, халамж12
4. Эрүүл мэнд13
5. Гэмт хэрэг15

II. Макро эдийн засгийн үзүүлэлт.....17

1. Дотоодын нийт бүтээгдэхүүн
2. Үнэ17
Орон сууцны үнийн индекс
3. Мөнгө, зээл, үнэт цаас21
4. Улсын нэгдсэн төсөв25
5. Гадаад худалдаа26
6. Гадаад худалдаа27
7. Бизнес регистрийн сан

III. Үйлдвэрлэл, үйлчилгээ29

1. Хөдөө аж ахуй29
2. Аж үйлдвэр31
3. Барилга32
4. Тээвэр, холбоо
5. Аялал, жуулчлал

IV. Бусад34

1. Цаг уур, агаарын бохирдолт34

V. Хавсралт хүснэгтүүд36

VII. Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм51

Ерөнхий тэмдэглэл

I. Үгийн товчлол:

I.1 Аймаг, нийслэл

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БХ	Баянхонгор
БУ	Булган
ГО	Говь-Алтай
ДО	Дорноговь
ДД	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
ДА	Дархан-Уул
УБ	Улаанбаатар
ОР	Орхон
ГС	Говьсүмбэр

I.2 Бусад

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

...	мэдээлэл байхгүй
0.0	маш бага тоо
-	гүйцэтгэл байхгүй.



Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал

(2013 оны эхний хагас жилийн байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт

Улсын хэмжээнд 2013 оны эхний хагас жилд 38729 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 2784 эх буюу 7.7 хувь, амьд төрсөн хүүхдийн тоо 6572 болж, 507 хүүхэд буюу 8.4 хувиар өслөө.

Улсын хэмжээнд 2013 оны эхний хагас жилд нялхсын эндэгдэл 577 болж, өмнөх оны мөн үеийнхээс 13 хүүхэд буюу 2.2 хувиар буурч, 1-5 хүртэлх насандаа 133 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 12 хүүхэд буюу 9.9 хувиар өсөв.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2013 оны 6 дугаар сарын эцэст 41.7 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 5.7 мян.хүн буюу 12.0 хувиар буурчээ.

Нийгмийн даатгалд 2013 оны эхний хагас жилд 641.3 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 423.4 мянга буюу 66.0 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагынх, 217.9 мянга буюу 34.0 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 55.6 мянга буюу 9.5 хувь, үүнээс аж ахуйн нэгж, байгууллагынх 41.3 мянга буюу 10.8 хувь, төсөвт байгууллагынх 14.3 мянга буюу 7.0 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2013 оны эхний хагас жилд 63.7 мян.хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 9.8 мян.хүн буюу 18.2 хувь, олгосон тэтгэврийн хэмжээ 12.8 тэрбум төг буюу 50.3 хувиар нэмэгджээ.

Хүний хөгжил сангаас 2013 оны эхний хагас жилд 18 хүртэлх насны 919.8 мянган хүүхдэд 111.2 тэрбум төгрөгийг хүүхдийн мөнгөнд, 113.7 мянган иргэнд 15.2 тэрбум төгрөгийн хувь хишиг, 4.9 мянган ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 4.6 тэрбум төгрөгийг 1 сая төгрөгийн хишиг хувьд зориулан олгожээ.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2013 оны эхний хагас жилд 21756 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2449 хүн буюу 10.1 хувиар буурахад салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 1656 хүн буюу 2.0 дахин, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 828 хүн буюу 35.7 хувиар өссөн хэдий ч

вируст гепатитаар өвчлөгчдийн тоо 2366 хүн буюу 59.8 хувь, гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 2124 хүн буюу 31.3 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 188 хүн буюу 8.7 хувиар буурснаас голлон шалтгаалжээ.

Улсын хэмжээнд 2013 оны эхний хагас жилд 12793 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1595 хэрэг буюу 14.2 хувиар өсчээ. Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (1146), хүний амь бие эрүүл мэндийн эсрэг (499) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 2013 оны эхний хагас жилд 4456 хүн гэмтэж, 495 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 196 буюу 4.6 хувиар өсч, нас барсан хүний тоо 8 буюу 1.6 хувиар буурсан байна.

II. Макро эдийн засгийн үзүүлэлт

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2012 оны гүйцэтгэлээр, оны үнээр 14012.9 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5498.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 2925.2 тэрбум төг буюу 26.4 хувь, зэрэгцүүлэх үнээр 606.6 тэрбум төг буюу 12.4 хувиар өслөө.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2012 оны гүйцэтгэлээр 14588.0 тэрбум төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5529.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 3419.8 тэрбум төг буюу 30.6 хувь, зэрэгцүүлэх үнээр 618.8 тэрбум төгрөг буюу 12.6 хувиар өслөө.

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮҮИ) 2013 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 0.3 хувиар буурч, оны эхнээс 4.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 8.8 хувиар өслөө. Ерөнхий индекс өмнөх сарынхаас буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 0.7 хувь, тээврийнх 0.9 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2013 оны 6 дугаар сарын эцэст 8004.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 96.2 тэрбум төг буюу 1.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 952.8 тэрбум төг буюу 13.5 хувиар өсчээ.



Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2013 оны 6 дугаар сарын эцэст 835.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 4.8 тэрбум төг буюу 0.6 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 55.7 тэрбум төг буюу 6.2 хувиар буурчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2013 оны 6 дугаар сарын эцэст 8607.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 381.3 тэрбум төг буюу 4.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2289.5 тэрбум төг буюу 36.2 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2013 оны 6 дугаар сарын эцэст 149.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 3.3 тэрбум төг буюу 2.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 97.9 тэрбум төг буюу 2.9 дахин өсчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2013 оны 6 дугаар сарын эцэст 316.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 1.4 тэрбум төг буюу 0.4 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 8.8 тэрбум төг буюу 2.8 хувиар өссөн байна.

Үнэт цаасны арилжаагаар 2013 оны эхний 6 сард 12.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 22.0 сая ш үнэт цаас арилжигдсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс үнэт цаасны гүйлгээ 48.6 тэрбум төг буюу 79.8 хувь, арилжигдсан үнэт цаасны тоо 86.2 сая ш буюу 79.7 хувиар буурчээ.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2013 оны эхний хагас жилд 2504.9 тэрбум төг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2637.9 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 133.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн урсгал орлого 2504.5 тэрбум төг, урсгал зардал 2353.8 тэрбум төг болж, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 150.7 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Татварын нийт орлого 66.2 тэрбум төг буюу 3.1 хувиар нэмэгдэхэд бусад татварын орлого 209.9 тэрбум төг буюу 43.4 хувиар буурсан хэдий ч бусад дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 115.0 тэрбум төг буюу 15.6 хувь, орлогын албан татварын орлого 87.5 тэрбум төг буюу 21.9 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 71.8 тэрбум төг буюу 22.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оны мөн

үеийнхээс 90.5 тэрбум төг буюу 37.4 хувиар өсөхөд хувьцааны ногдол ашгийн орлого 19.9 тэрбум төг буюу 82.2 хувь, бусад нэр заагдаагүй орлого 4.6 тэрбум төг буюу 14.2 хувиар буурсан хэдий ч торгуулийн орлого 53.0 тэрбум төг буюу 2.8 дахин, газрын тосны орлого 31.4 тэрбум төг буюу 2.0 дахин, төсөвт газрын өөрийн орлого 25.5 тэрбум төг буюу 24.4 хувь, навигацын орлого 4.7 тэрбум буюу 24.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2013 оны эхний хагас жилд 2637.9 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 292.2 тэрбум төг буюу 10.0 хувиар буурсан нь бараа, үйлчилгээний зардал 347.4 тэрбум төг буюу 37.1 хувь, зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 37.0 тэрбум төг буюу 67.0 хувиар өссөн хэдий ч хөрөнгийн зардал 353.6 тэрбум төг буюу 58.3 хувь, татаас ба шилжүүлгийн зардал 313.0 тэрбум төг буюу 24.2 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 10.0 тэрбум төг буюу 24.2 хувиар буурснаас шалтгаалжээ.

Монгол Улс 2013 оны эхний хагас жилд дэлхийн 120 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 5094.5 сая ам.долл, үүнээс экспорт 2023.7 сая ам.долл, импорт 3070.7 сая ам.долларт хүрчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2013 оны эхний хагас жилд 1.0 тэрбум ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 13.1 сая ам.долл буюу 1.2 хувиар буурчээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 472.0 сая ам.долл буюу 8.5 хувь, үүний дотор импортын хэмжээ 242.5 сая ам.долл буюу 7.3 хувь, экспортын хэмжээ 229.4 сая ам.долл буюу 10.2 хувиар буурчээ.

Экспортын 97.4 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, нэхмэл бүтээгдэхүүн, авто ба агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги эзэлж байна.

III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт

Том малын зүй бус хорогдол 2013 оны эхний хагас жилд, улсын хэмжээнд 638.4 мян. толгойд хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 362.8



мян.толгой буюу 2.3 дахин нэмэгдсэн байна. Том малын зүй бус хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 29.5 мянга, үхэр 63.1 мянга, тэмээ 0.9 мянга, хонь 278.0 мянга, ямаа 267.0 мянга байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2013 оны эхний хагас жилд 1104.8 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 59.1 тэрбум төг буюу 5.7 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд зэсийн баяжмал, газрын тос, алт зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 12.8-76.1 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарын амтат ус, ундаа, шар айраг, ган төмөр хийц, хиаман төрлийн бүтээгдэхүүн, зүсмэл материал, хивс, гурил, барилгын модон хаалга, цонх, самнасан ноолуур, бетон зуурмаг, савласан ногоон цай зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.1 хувиас 6.5 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Бүх төрлийн тээврээр 2013 оны эхний хагас жилд 19.0 сая т ачаа, давхардсан тоогоор 181.3 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 1.4 сая т буюу 6.9 хувиар буурч, харин зорчигчдын тоо 31.6 сая хүн буюу 21.1 хувиар өсчээ.

Төмөр замын тээврээр 2013 оны эхний хагас жилд 10066.3 мян.т ачаа, давхардсан тоогоор 1886.9 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 174.1 мян.т буюу 1.8 хувиар өсч, зорчигчдын тоо 72.9 мян.хүн буюу 3.7 хувиар буурсан байна.

Агаарын тээврээр 2013 оны эхний хагас жилд 1916.9 т ачаа, давхардсан тоогоор 346.1 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 40.5 т буюу 2.2 хувь, зорчигчдын тоо 24.8 мян.хүн буюу 7.7 хувиар өсчээ.

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр хамгийн их хур тунадас 2013 оны 6 дугаар сард Дархан-Уул аймгийн Дархан суманд орж 125.0 мм-т хүрчээ. Энэ оны 6 дугаар сард Өмнөговь аймгийн Ханбогд суманд хамгийн их температур 37.5 хэм, Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ суманд хамгийн бага температур -6.4 хэм байлаа. Салхины хамгийн их хурд Говь-Алтай аймгийн Алтай, Хэнтий аймгийн Өндөрхаан суманд 28 м/с хүрчээ.

Азотын давхар ислийн хоногийн дундаж

агууламж 2013 оны 6 дугаар сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 30 удаа, Баруун дөрвөн замын орчимд 23 удаа, 32-ын тойрог орчимд 1 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн замын орчимд 18 удаа, Хархорин захын орчимд 14 удаа, 32-ын тойрог орчимд 10 удаа, 13-р хороолол орчимд 6 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 13-р хороолол орчимд 5 удаа, Баруун дөрвөн замын орчимд 2 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Аюулт үзэгдэл, осол 2013 оны эхний хагас жилд 2587 удаа гарсны улмаас 79 хүн амь насаа алдаж, 232.1 мян.толгой мал, амьтан хорогджээ. Энэ оны эхний хагас жилд объектын түймэр 2282 удаа, ой, хээрийн түймэр 124 удаа, мал, амьтны халдварт галзуу өвчин 44 удаа, гол, нуурын усанд хүн унасан осол 29 удаа, 3.5-аас дээш магнитудын газар хөдлөлт 27 удаа, хүчтэй салхи шуурга 23 удаа, аадар бороо, үерийн аюулт үзэгдэл 12 удаа, химийн хорт бодисын алдагдалтай холбоотой ослын дуудлага 11 удаа, бичил уурхайн нурангины осол, үхрийн хорт салст халуурал өвчин, сум галт хэрэгслийн осол тус бүр 7 удаа, аянгын аюулт үзэгдэл, тэсэрч дэлбэрэх бодисын осол тус бүр 3 удаа, малын халдварт боом өвчин, үйлдвэрлэлийн осол тус бүр 2 удаа, зуд, малын халдварт маеди весна өвчин, малын гоц халдварт цэцэг өвчин, хоолны хордлого тус бүр 1 удаа бүртгэгджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас энэ оны эхний хагас жилд объектын түймэрт 6.8 тэрбум төг, ой, хээрийн түймэрт 3.0 тэрбум төг, хүчтэй салхи шуурганд 609.5 сая төг, мал, амьтны халдварт галзуу өвчинд 13.6 сая төг, малын халдварт боом, үхрийн хорт салт халуурал өвчин, тэсэрч дэлбэрэх бодисын осол, үйлдвэрлэлийн ослоор нийтдээ 8.6 сая төгрөгийн хохирол иргэн болон байгууллагад учирсан байна. Объектын түймрээр 38 хүн, гол нуурын усанд унасан ослоор 30 хүн, бичил уурхайн нурангины ослоор 6 хүн, ой, хээрийн түймрээр 2 хүн, аадар бороо үерийн аюулт үзэгдэл, хүчтэй салхи шуурга, үйлдвэрлэлийн ослоор тус бүр 1 хүн амь насаа алджээ.

Өмнөх оны мөн үеийнхээс аюулт үзэгдэл, ослын тохиолдол 265-аар нэмэгдэв.

Хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтдын тоо 2013 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеийнхээс 224.8 мян.толгойгоор их байна.



I. Нийгмийн үзүүлэлт

Зураг I.1


I.1 Хүн ам

Улсын хэмжээнд 2013 оны эхний хагас жилд 38729 эх амаржиж, 38937 хүүхэд төрүүлсэн байна. 1000 хүнд ногдох төрөлт 13.9, нас баралт 2.9, ердийн цэвэр өсөлт 11.0 болов (Зураг I.1). Өмнөх оны мөн үеийнхээс 1000 хүнд ногдох төрөлт 0.7 пунктээр нэмэгдэж, нас баралт 0.3 пунктээр буурч, хүн амын ердийн цэвэр өсөлт 1.0 пунктээр өслөө.

Энэ оны эхний хагас жилд 1000 хүнд ногдох төрөлт Говьсүмбэр аймагт 3.1 пунктээр, Баянхонгорт 1.2, Баян-Өлгий, Орхонд тус бүр 0.8, Ховдод 0.7, Хөвсгөлд 0.3 болон Улаанбаатар хотод 1.7 пунктээр улсын дунджаас дээгүүр, Төв аймагт 7.1 пунктээр, Сэлэнгэд 4.7, Булганд 4.3, Дундговьд 2.6, Сүхбаатарт 2.5, Завханд 2.4, Өмнөговь, Дорноговь тус бүр 1.9, Хэнтийд 1.8, Архангайд 1.1, Өвөрхангай, Говь-Алтайд тус бүр 0.7, Дорнод, Увс аймагт тус бүр 0.3 пунктээр улсын дунджаас доогуур, Дархан-Уул аймагт улсын дундаж түвшинд байна.

Улсын дунджаас 1000 хүнд ногдох нас баралт Хөвсгөл аймагт 0.6 пунктээр, Сүхбаатарт 0.5, Завхан, Өвөрхангай, Дорнодод тус бүр 0.3, Баянхонгорт 0.2, Дархан-Уул, Дорноговь, Дундговь аймаг болон Улаанбаатар хотод тус бүр 0.1 пунктээр дээгүүр, Төв, Говьсүмбэрт тус

Төрөлт, нас баралт, ердийн цэвэр өсөлт, 1000 хүнд ногдохоор, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Эх сурвалж: Эрүүл Мэндийн Яамны мэдээлэл

бүр 0.8 пунктээр, Өмнөговьд 0.7, Сэлэнгэд 0.6, Хэнтий, Баян-Өлгийд 0.5, Булганд 0.4, Ховдод 0.3, Орхон, Архангай, Увс, Говь-Алтай аймагт тус бүр 0.1 пунктээр улсын дунджаас доогуур байна.

Хүн амын ердийн цэвэр өсөлт Говьсүмбэр аймагт 3.9 пунктээр, Баян-Өлгийд 1.3, Ховдод, Баянхонгорт тус бүр 1.0, Орхонд 0.9, Улаанбаатар хотод 1.6 пунктээр улсын дунджаас дээгүүр, бусад аймагт 0.1-6.3 пунктээр доогуур байна.


I.2 Бүртгэлтэй ажилгүй иргэн*

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2013 оны 6 дугаар сарын эцэст 41.7 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 5.7 мян.хүн буюу 12.0 хувиар буурч, 2013 оны 5 дугаар сарынхаас 1.2 мян.хүн буюу 3.0 хувиар нэмэгдсэн байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 22.1 мянга буюу 52.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 1.8 пунктээр өсчээ. Аймаг, нийслэлийн хөдөлмөрийн хэлтэст 2013 оны эхний хагас жилд ажилгүй 53.9 мян. иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 28.6 мян.иргэн ажилд зуучлагдан орж, 11.8 мян.иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ (Зураг I.2).

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.4 хувийг магистр, доктор, 23.5 хувийг дипломын болон бакалаврын, 7.5 хувийг тусгай мэргэжлийн дунд, 7.2 хувийг техникийн болон мэргэжлийн, 42.5 хувийг бүрэн дунд, 13.4 хувийг суурь, 4.4 хувийг бага боловсролтой, 1.1 хувийг

Зураг I.2

Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, жил бүрийн эхний хагас жилд





боловсролгүй иргэд эзэлж байна (Зураг 1.3). Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 24.9 мянга буюу 59.7 хувь нь 15-34 насны залуучууд байгаа бөгөөд энэ үзүүлэлт Ховд, Сүхбаатар, Өмнөговь, Дорноговь, Баян-Өлгий, Сэлэнгэ, Төв, Дорнод, Говь-Алтай, Архангай болон Орхон аймагт улсын дунджаас 0.9-9.0 пунктээр их байна.

Ажлын шинэ байр *


Хөдөлмөрийн яамны мэдээгээр 2013 оны эхний хагас жилд 27073 хүн ажлын шинэ байранд ажилд орсны 12647 нь буюу 46.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажлын шинэ байранд ажилд орсон ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилбал, 21.0 хувийг барилгын, 17.2 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн, 15.8 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны, 9.3 хувийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын, 8.3 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 4.9 хувийг тус бүр уул уурхай, олборлолт болон төрийн удирдлага ба батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгааллын, 3.4 хувийг боловсролын, 3.3 хувийг тээвэр ба агуулахын үйл ажиллагааны, 2.8 хувийг зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний, 2.2 хувийг хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны, 6.9 хувийг бусад салбарын ажиллагчид эзэлж байна (Зураг 1.4).

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн 4698 буюу 17.4 хувь нь 15-24 насны, 9636 буюу 35.6 хувь нь 25-34, 6915 буюу 25.5 хувь нь 35-44, 5448 буюу 20.1 хувь нь 45-59, 376 буюу 1.4 хувь нь 60, түүнээс дээш насны хүмүүс байна (Зураг 1.5).

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд 0.2 хувь нь зэвсэгт хүчний ажил мэргэжилтэй, 1.6 хувь нь техникч болон туслах/дэд мэргэжилтэн, 3.2 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 4.4 хувь нь менежер, 6.3 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 7.7 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан, 10.7 хувь нь худалдаа, үйлчилгээ, 14.6 хувь нь мэргэжилтэн, 24.3 хувь нь энгийн ажил мэргэжилтэй, 27.0 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын холбогдох үйлчилгээний мэргэжилтэй хүмүүс байна.


Зураг 1.3

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2013 оны 6 дугаар сарын эцэст



Зураг 1.4


Ажлын шинэ байранд ажилд орсон иргэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2013 оны эхний хагас жилд



* - Эх үүсвэр: Хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээ

Зураг 1.5

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэд, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2013 оны эхний хагас жилд





Гадаад иргэд

Манай улсад 2013 оны эхний хагас жилд 103 орны 23.3 мян.иргэн хөдөлмөр эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1 орноор, ажиллагчдын тоо 24.6 хувиар буурчээ.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй нийт ажиллагчдын 72.7 хувь нь БНХАУ-ын, 9.1 хувь нь БНАСАУ-ын, 2.8 хувь нь ОХУ-ын, 2.3 хувь нь БНСУ-ын, 2.1 хувь нь БНСВУ-ын, 1.6 хувь нь АНУ-ын, 1.5 хувь нь Австрали улсын, 7.9 хувь нь бусад улсын харьяат иргэд байна. Өмнөх оны мөн үеийнхээс манай улсад хөдөлмөр эрхэлж буй БНАСАУ-ын иргэдийн тоо 24.0 хувиар, БНСВУ-ынх 10.5 хувиар, БНСУ-ынх 0.2 хувиар өсч, БНХАУ-ынх 30.4 хувиар, АНУ-ынх 27.9 хувиар, Австрали улсынх 17.9 хувиар, ОХУ-ынх 16.3 хувиар буурчээ.

Манай улсад хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн 10926 хүн буюу 46.9 хувь нь барилгын, 5049 хүн буюу 21.6 хувь нь уул уурхай, олборлолтын, 2367 хүн буюу 10.1 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 2163 хүн буюу 9.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 714 хүн буюу 3.1 хувь нь тээвэр

1.3 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2013 оны эхний хагас жилд 613.2 тэрбум төг, зарлага 522.8 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 124.4 тэрбум төг буюу 25.4 хувь, зарлага 104.0 тэрбум төг буюу 24.8 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2013 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеийнхээс 124.4 тэрбум төгрөгөөр өсөхөд ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 157.7 сая төг буюу 1.0 хувиар буурсан хэдий ч тэтгэврийн даатгалын сангийн орлого 86.3 тэрбум төг буюу 24.7 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Харин нийгмийн даатгалын сангийн зарлага 2013 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеийнхээс 104.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 90.1 тэрбум төг буюу 28.0 хувь, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 9.1 тэрбум төг буюу 47.4 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.


Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2013 оны эхний хагас

Зураг 1.6
Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, хувиар, 2013 оны эхний хагас жилд



ба агуулахын үйл ажиллагааны, 651 хүн буюу 2.8 хувь нь боловсролын, 401 хүн буюу 1.7 хувь нь захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны, 298 хүн буюу 1.3 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуйн, 738 хүн буюу 3.2 хувь нь бусад салбарт ажиллаж байна (Зураг 1.6).

Зураг 1.7
Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн бүтэц, төрлөөр, хувиар, 2013 оны эхний хагас жилд



жилд 401.3 тэрбум төг болсны 73.2 хувийг өндөр настны тэтгэвэр, 12.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, 8.8 хувийг цэргийн тэтгэвэр, 5.8 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс өндөр настны тэтгэвэр 28.8 хувь, цэргийн тэтгэвэр 31.6 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр 25.1 хувь, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 19.6 хувиар өсчээ. (Зураг 1.7)



Нийгмийн даатгалд 2013 оны эхний хагас жилд 641.3 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 423.4 мянга буюу 66.0 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагынх, 217.9 мянга буюу 34.0 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 55.6 мянга буюу 9.5 хувь, үүнээс аж ахуйн нэгж, байгууллагынх 41.3 мянга буюу 10.8 хувь, төсөвт байгууллагынх 14.3 мянга буюу 7.0 хувиар нэмэгдсэн байна.

Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2013 оны эхний хагас жилд 178.3 мян.хүнд 65.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 12.4 мян.хүн буюу 7.4 хувиар өсч, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 19.6 тэрбум төг буюу 42.7 хувиар өсчээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын 43.9 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, 35.7 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 10.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 9.2 хувь нь ахмад настныг асарч буй иргэд, 1.2 хувь нь бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөж буй иргэд байна. (Зураг 1.8).


Нийгмийн халамжийн сангаас 2013 оны эхний хагас жилд олгосон нийт тэтгэвэр, тэтгэмжийн 38.2 тэрбум төг буюу 58.3 хувийг халамжийн тэтгэвэрт, 17.2 тэрбум төг буюу 26.2 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд, 5.3 тэрбум төг буюу 8.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд, 4.2 тэрбум төг буюу 6.5 хувийг ахмад настныг асарч буй иргэдэд, 655.9 сая төг буюу 1.0 хувийг бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмжид зарцуулсан байна. (Зураг 1.9).

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2013 оны эхний хагас жилд 63.7 мян.хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 9.8 мян.хүн буюу 18.2 хувь, олгосон тэтгэврийн хэмжээ 12.8 тэрбум төг буюу 50.3 хувиар өсчээ.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 249.8 мян.хүн хамрагдсаны 19.1 хувь нь ахмад настан, 70.2 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 4.5 хувь

Зураг 1.8

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын бүтэц, хувиар, 2013 оны эхний хагас жилд



Зураг 1.9

Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц, хувиар, 2013 оны эхний хагас жилд



нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 5.3 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд, 0.9 хувь нь алдар цолтой ахмадууд байна.

Хүний хөгжил сангаас 2013 оны эхний хагас жилд 18 хүртэлх насны 919.8 мянган хүүхдэд 111.2 тэрбум төгрөгийг хүүхдийн мөнгөнд, 113.7 мянган иргэнд 15.2 тэрбум төгрөгийн хувь хишиг, 4.9 мянган ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 4.6 тэрбум төгрөгийг 1 сая төгрөгийн хишиг хувьд зориулан олгожээ.



I.4 Эрүүл мэнд

Улсын хэмжээнд 2013 оны эхний хагас жилд 38729 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 38937 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 2784 буюу 7.7 хувиар, хүүхдийн тоо 2808 буюу 7.8 хувиар өссөн байна (Зураг I.10). Энэ оны 6 дугаар сард 6572 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 507 хүүхэд буюу 8.4 хувиар нэмэгдлээ.

Энэ оны эхний хагас жилд нялхсын эндэгдэл 577 болж, өмнөх оны мөн үеийнхээс 13 хүүхэд буюу 2.2 хувиар буурч, 1-5 хүртэлх насандаа 133 хүүхэд эндэж, 12 хүүхэд буюу 9.9 хувиар өсчээ (Зураг I.11). Энэ оны эхний хагас жилд жирэмслэлт болон төрөлтийн улмаас 15 эх энджээ.



Нялхсын эндэгдэл 2013 оны 6 дугаар сард 85 болж, өмнөх оны мөн үеийнхээс 13 хүүхдээр, 1-5 хүртэлх насандаа 20 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 2 хүүхдээр буурчээ.

1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2013 оны эхний хагас жилд 15 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1 хүүхдээр буурсан бөгөөд энэ үзүүлэлт Хөвсгөл (27), Говь-Алтай (25), Сүхбаатар (23), Баянхонгор (21) аймагт 6-12 хүүхдээр, Өмнөговь (20), Увс (20), Архангай (17), Дорноговь (16), Баян-Өлгий (16) аймагт 1-5 хүүхдээр илүү байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2013 оны 6 дугаар сард 105 болж, өмнөх оны мөн үеийнхээс 15 хүүхдээр буурсан байна. 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл энэ оны эхний хагас жилд 18 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2 хүүхдээр буурсан байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2013 оны эхний хагас жилд 21756 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2449 хүн буюу 10.1 хувиар буурахад салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 1656 хүн буюу 2.0 дахин, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 828 хүн буюу 35.7 хувиар өссөн хэдий ч вирүст гепатитаар өвчлөгчдийн тоо 2366 хүн буюу 59.8 хувь, гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 2124 хүн буюу 31.3 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 188 хүн буюу 8.7 хувиар буурснаас голлон шалтгаалжээ.

Энэ оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад салхин цэцгээр өвчлөгчдийн тоо Дорноговь аймагт 210 хүн



буюу 6.7 дахин, Дорнод аймагт 312 хүн буюу 5.7 дахин, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо Говьсүмбэр аймагт 27 хүн буюу 2.9 дахин, Сүхбаатар аймагт 65 хүн буюу 2.5 дахин өсчээ. Харин вирүст гепатитаар өвчлөгчдийн тоо Дундговь аймагт 104 хүн буюу 6.8 дахин, Дорнод аймагт 122 хүн буюу 5.5 дахин, гахайн хавдраар өвчлөгчдийн тоо Улаанбаатар хотод 4663 хүн буюу 5.1 дахин, трихомониазаар өвчлөгчдийн тоо Булган аймагт 135 хүн буюу 4.6 дахин буурчээ.

Халдварт өвчнөөр 2013 оны 6 дугаар сард 3209 хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 931 хүн буюу 22.5 хувиар буурлаа.

Хачигт рикеттиоз өвчний тохиолдол энэ оны эхний хагас жилд 22 бүртгэгдсэнээс 6 дугаар сард 17 бүртгэгдэв.



10 000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2013 оны эхний хагас жилд улсын дунджаар 78 болж, өмнөх оны мөн үеийнхээс 11 хүнээр буурав (Зураг I.12).

Улаанбаатар хотод энэ оны 6 дугаар сард ХДХВ/ДОХ-ын тохиолдол 2 илэрч, улсын хэмжээнд бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын нийт тохиолдол 143 боллоо.

Улсын хэмжээнд 2013 оны эхний хагас жилд 8044 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс 667 хүн буюу 7.7 хувиар буурчээ (Зураг I.13). Эмнэлэгт нас барсан хүний тоо энэ оны эхний хагас жилд 1957 болж, өмнөх оны мөн үеийнхээс 202 хүн буюу 9.4 хувиар буурав. Энэ нь нийт нас баралтын 24.3 хувийг эзэлж байна. Нас барсан хүний тоо энэ оны 6 дугаар сард 1231 болж, өмнөх оны мөн үеийнхээс 152 хүн буюу 11.0 хувиар буурчээ.

Энэ оны эхний хагас жилд 378.6 мян.хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 6992 хүн буюу 1.9 хувиар нэмэгджээ. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2013 оны 6 дугаар сард 59.3 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 2738 хүн буюу 4.8 хувиар нэмэгдэв.

Хувийн эмнэлгүүд 2013 оны эхний хагас жилд 668.9 мян.хүнд үйлчилж 22.9 тэрбум төгрөгийн төлбөртэй үйлчилгээ үзүүлжээ. Хувийн эмнэлгээр үйлчлүүлсэн хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 3.6 хувиар буурч, төлбөрт үйлчилгээний хэмжээ 10.6 хувиар өсөв.


I.5 Гэмт хэрэг

Улсын хэмжээнд 2013 оны эхний хагас жилд 12793 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1595 хэрэг буюу 14.2 хувиар өсчээ. (Зураг I.14). Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (1146), хүний амь бие эрүүл мэндийн эсрэг (499) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 60.0 хувь нь нийслэлд, 39.0 хувь нь аймгуудад, 0.5 хувь нь төмөр замын цагдаагийн хэлтэст, 0.5 хувь нь иргэний агаарын тээврийн салбар болон бусад газарт 2013 оны эхний хагас жилд бүртгэгджээ.


Зураг I.12

10 000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар




Зураг I.13

Нас барсан хүний тоо, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Зураг I.14

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар





Бүртгэгдсэн гэмт хэргийн 46.6 хувийг хүндэвтэр, 44.6 хувийг хөнгөн, 7.0 хувийг хүнд, 1.8 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс хөнгөн хэргийнх 1.7 пункт, хүндэвтэр хэргийнх 1.3 пунктээр өсч, хүнд хэргийнх 2.2 пункт, онц хүнд хэргийнх 0.8 пунктээр буурсан байна. (Зураг I.15).

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеийнхээс Ховд аймагт 40.5 хувь, Дорнод аймагт 34.1 хувь, Баянхонгор аймагт 30.3 хувь, Булган аймагт 29.1 хувь, Сүхбаатар аймагт 27.9 хувь, Орхон аймагт 25.1 хувь, Төв аймагт 25.1 хувь, Улаанбаатар хотод 20.3 хувь, Өмнөговь аймагт 14.4 хувь, Дундговь аймагт 10.5 хувь, Хөвсгөл аймагт 8.3 хувь, Архангай аймагт 8.4 хувь, Говьсүмбэр аймагт 7.8 хувь, Говь-Алтай аймагт 2.2 хувь, Сэлэнгэ аймагт 2.0 хувиар нэмэгдсэн бол Хэнтий аймагт 37.4 хувь, Увс аймагт 11.4 хувь, Баян-Өлгий аймагт 11.2 хувь, Өвөрхангай аймагт 9.8 хувь, Дорноговь аймагт 5.3 хувь, Завхан аймагт 1.7 хувь, Дархан-Уул аймагт 1.5 хувиар буурчээ. Ховд, Дорнод, Баянхонгор аймгуудад гэмт хэрэг 30.3-40.5 хувиар өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (38-71), хулгайн гэмт хэрэг (37-69) өссөн нь нөлөөлөв.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 159 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 159 хэрэг буюу 50.0 хувиар буурсан байна. Малын хулгайн 669 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 5.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 87 хэрэг буюу 11.5 хувиар буурчээ.


Сэжигтэн нь тодорхойгүй байсан 5475 хэргийн 52.9 хувийнх нь холбогдогч нь тогтоогдож, яллагдагчаар татагдсанаар гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд өмнөх оны мөн үеийнхээс 6.4 пунктээр, нийслэлийн хэмжээнд 4.7 пунктээр буурсан байна. (Зураг I.16).

Хүүхэд оролцсон гэмт хэрэг 2013 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеийнхээс 72.3 хувь, эмэгтэй хүн оролцсон хэрэг 52.0 хувь, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 35.8 хувь, бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 1.1 хувиар нэмэгджээ.

18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэргийн тоо улсын дунджаар 2013 оны эхний хагас жилд 68 болж, өмнөх оны мөн үеийнхээс 9 хэрэг буюу 15.3 хувиар нэмэгдсэн байна.


Зураг I.15

Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэргийн ангиллаар, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, хувиар



Зураг I.16

Гэмт хэргийн илрүүлэлт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, хувиар



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч 2013 оны эхний хагас жилд 10597 байгаагийн 673 буюу 6.4 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 1522 буюу 14.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэрэгт холбогдогчдын 4.3 хувь нь өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүс байгаа бөгөөд тэдгээрийн эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхээс 0.6 пунктээр буурчээ.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдад хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь 2013 оны эхний хагас жилд 13.8 болж, өмнөх оны мөн үеийнхээс 3.2 пункт, төрийн бус байгууллагын ажиллагчдынх 2.3 болж 0.5 пункт, оюутан сурагчдынх 7.7 болж 0.4 пунктээр нэмэгдэж, харин малчдынх 8.5 хувь болж 1.2 пункт, ажилгүй иргэдийнх 53.0 хувь болж 1.3 пункт, төрийн албан хаагчдынх 4.0 хувь болж 0.3 пункт, аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдынх 9.4 хувь болж 1.3 пунктээр буурсан байна.



Бүртгэгдсэн гэмт хэргийн 29.1 хувь нь гэр, орон сууцанд, 21.5 хувь нь гудамж, талбайд, 13.8 хувь нь олон нийтийн газарт, 7.1 хувь нь аж ахуйн нэгжид, 6.5 хувь нь авто замд, 2.7 хувь нь төрийн байгууллагад, 1.3 хувь нь төрийн бус байгууллагад, 0.9 хувь нь нийтийн тээврийн хэрэгсэлд, 16.9 хувь нь бусад газарт 2013 оны эхний хагас жилд үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 4456 хүн гэмтэж, 495 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 196 буюу 4.6 хувиар нэмэгдэж, харин нас барсан хүний тоо 8 буюу 1.6 хувиар буурсан байна. (Зураг I.18).

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2013 оны эхний хагас жилд 45.9 тэрбум төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 14.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 22.4 тэрбум төг буюу 95.2 хувь, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 2.5 тэрбум төг буюу 21.5 хувиар нэмэгдсэн байна. (Зураг I.19). Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 14.7 тэрбум төг буюу 32.0 хувь нь төрийн өмчид ногдож байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2013 оны эхний хагас жилд 12203 байгаагийн 746 буюу 6.1 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 4813 буюу 39.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэргийн улмаас нийт 87 байгууллагад хохирол учирсны 58 нь төрийн, 4 нь төрийн бус, 25 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага байна.

Улсын хэмжээнд 2013 оны эхний хагас жилд 61.5 мян.хүн эрүүлжүүлэгдэж, 8.1 мян.хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 0.4 мянга буюу 0.6 хувиар буурч, харин баривчлагдсан хүний тоо 1115 буюу 15.9 хувиар өссөн байна.


Зураг I.17

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын нийгмийн байдал, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, хувиар




Зураг I.18

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Зураг I.19

Гэмт хэргийн хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, тэрбум төг





II. Макро эдийн засгийн үзүүлэлт

II.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн ДНБ, үйлдвэрлэлийн аргаар

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2012 оны гүйцэтгэлээр, оны үнээр 14012.9 тэрбум төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5498.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 2925.2 тэрбум төг буюу 26.4 хувь, зэрэгцүүлэх үнээр 606.6 тэрбум төг буюу 12.4 хувиар өслөө (Зураг II.1).

ДНБ-ий 2012 оны 12.4 хувийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар 24.6 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбар 9.4 хувь, уул уурхай, олборлох салбар 8.0 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар 39.4 хувь, барилгын салбар 38.9 хувь өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ДНБ, эцсийн ашиглалтын аргаар

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2012 оны гүйцэтгэлээр 14588.0 тэрбум төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5529.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 3419.8 тэрбум төг буюу 30.6 хувь, зэрэгцүүлэх үнээр 618.8 тэрбум төг буюу 12.6 хувиар өслөө. Уг өсөлтөд эцсийн хэрэглээ болон нийт хуримтлал нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

ДНБ (оны үнээрх)-д 2012 оны гүйцэтгэлээр эцсийн хэрэглээ 64.2 хувь, нийт хуримтлал 61.4 хувь, цэвэр экспорт -25.6 хувийг эзэлж, өмнөх оныхоос хөрөнгийн нийт хуримтлал 0.7 пункт, цэвэр экспорт 1.3 пунктээр буурч, харин эцсийн хэрэглээ 1.9 пунктээр нэмэгдсэн байна (Зураг II.2).


ДНБ, орлогын аргаар

ДНБ, орлогын аргаар, оны үнээр 14012.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 2925.2 тэрбум төг буюу 26.4 хувиар өсөв.

ДНБ-д 2012 оны гүйцэтгэлээр цалин, түүнтэй адилтгах орлого 27.8 хувь, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар 18.3 хувь, үйл ажиллагааны цэвэр ашиг, холимог орлого 48.1 хувь, үндсэн хөрөнгийн хэрэглээ 5.9 хувьд хүрч, өмнөх оныхоос цалин, түүнтэй адилтгах орлого 3.6 пунктээр, үндсэн хөрөнгийн хэрэглээ 0.5 пунктээр нэмэгдэж, үйл ажиллагааны цэвэр ашиг, холимог орлого 1.3 пунктээр, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар 2.8 пунктээр буурсан байна (Зураг II.3).


Зураг II.1

ДНБ (үйлдвэрлэлийн аргаарх)-ий жилийн өсөлт, бууралт, хувиар, өмнөх оныхтой харьцуулснаар




Зураг II.2

ДНБ-ий эцсийн ашиглалтын бүтэц, хувиар



Зураг II.3

ДНБ-ий орлогын бүтэц, хувиар





II.2 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮҮИ) 2013 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 0.3 хувиар буурч, оны эхнээс 4.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 8.8 хувиар өслөө (Хүснэгт II.1).

Ерөнхий индекс 2013 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 0.3 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувь, орон сууц, ус, цахилгаан,

түлшний бүлгийнх 0.7 хувь, тээврийнх 0.9 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.6 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 0.5 хувь, гэр ахуйн тавилга, барааных 0.7 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 0.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 0.9 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 0.2 хувиар өсч, харин амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 0.7 хувиар буурсан бөгөөд эдгээрээс бусад бүлгийн үнэ өөрчлөлтгүй байв.

Хүснэгт II.1


Хэрэглээний үнийн улсын индекс, бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2013 VI		2013 VI	
		2012 VI	2012 VI	2012 XII	2013 V
Ерөнхий индекс	100.0	108.8	104.7	104.7	99.7
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	108.1	112.7	112.7	99.1
Согтууруулах ундаа, тамхи	3.2	150.8	102.2	102.2	100.6
Хувцас, бөс бараа, гутал	16.1	111.9	103.5	103.5	100.5
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	103.2	95.0	95.0	99.3
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	109.7	104.5	104.5	100.7
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	109.7	105.1	105.1	100.7
Тээвэр	12.2	104.1	101.6	101.6	99.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	99.5	99.8	99.8	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	100.3	99.3	99.3	99.3
Боловсролын үйлчилгээ	4.7	115.2	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	112.3	108.4	108.4	100.9
Бусад бараа, үйлчилгээ	4.1	105.8	102.4	102.4	100.2

Хэрэглээний үнийн улсын индекс 2013 оны 6 дугаар сард оны эхнээс 4.7 хувь өссөнөөс хүнс, ундаа, усны бүлгийн барааны үнэ дүнгээрээ 12.7 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 3.5 хувь, гэр ахуйн тавилга, барааных 4.5 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 5.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 8.4 хувиар нэмэгдсэн байна. Харин орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 5.0 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийнх 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 0.7 хувиар буурчээ.

Хэрэглээний үнийн улсын индекс 2012 оны 6 дугаар сард оны эхнээс 9.7 хувиар өссөн бол 2013 оны 6 дугаар сард 4.7 хувь болж, өсөлт 5.0 пунктээр саарсан байна (Зураг II.4).

Зураг II.4

Хэрэглээний үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100)



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2013 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас Дорнод (2.5%), Баянхонгор (2.2%), Говь-Алтай (2.1%), Дархан-Уул (1.0%), Говьсүмбэр (0.9), Архангай (0.9%), Сэлэнгэ (0.7%), Хэнтий (0.6%), Өмнөговь (0.3%), Төв (0.3%) аймагт буурч, Өвөрхангай аймагт өөрчлөлтгүй, бусад аймагт 0.2-1.9 хувиар өсчээ (Зураг II.5).

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2013 оны 6 дугаар сард баруун бүсэд өмнөх сарынхаас 0.6 хувь, оны эхнээс 5.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 11.0 хувиар өссөн, хангайн бүсэд өмнөх сарынхаас 0.1 хувиар буурч, оны эхнээс 7.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 13.7 хувиар өссөн, төвийн бүсэд өмнөх сарынхаас 0.3 хувиар буурч, оны эхнээс 5.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 8.0 хувиар өссөн, зүүн бүсэд өмнөх сарынхаас 1.3 хувь буурч, оны эхнээс 5.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 8.1 хувиар өссөн байна.

Өрхийн нийт хэрэглээнд өндөр хувийн жин эзэлж буй мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ дүнгээрээ 2013 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас Баянхонгор (13.0%), Дорнод (10.4%), Говьсүмбэр (8.4%), Говь-Алтай (8.1%) Архангай (6.3%), Төв (5.5%), Өвөрхангай (4.9%), Орхон (4.4%) Хэнтий (3.3%), Дундговь (3.1%), Булган (2.4%), Дархан-Уул (2.3%), Сэлэнгэ (0.5%), Увс (0.3%) аймагт буурч, Өмнөговь аймагт өөрчлөлтгүй, бусад 6 аймагт 0.4-6.9 хувиар өссөн байна. Завхан (6.9%) аймагт хамгийн их өсөлттэй байв.


Талх, гурил, будааны дэд бүлгийн үнэ Завхан (6.4%), Дорноговь (2.3%), Сэлэнгэ (1.5%), Орхон (0.3%), Говь-Алтай (0.1%) аймагт буурч, Архангай, Дархан, Ховд, Булган, Өвөрхангай аймагт өөрчлөлтгүй, бусад 11 аймагт 0.2-4.5 хувиар өссөн байна. Хөвсгөл (4.5%) аймагт хамгийн их өсөлттэй байлаа.

Сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ Өвөрхангай, Говьсүмбэр аймагт өөрчлөлтгүй, бусад 19 аймагт 6.1-24.4 хувиар буурсан байна. Говь-Алтай (24.4%) аймагт хамгийн их бууралттай байв.

Төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ Говь-Алтай (10.5%), Баянхонгор (8.4%), Дархан-Уул (7.1%), Хөвсгөл (5.4%), Дорнод (3.6%), Төв (2.0%), Сэлэнгэ (0.2%) аймагт буурч, бусад 14 аймагт 0.1-50.7 хувиар өсчээ. Ховд (50.7%) аймагт хамгийн их өсөлттэй байлаа.

Зураг-II.5

Хэрэглээний үнийн индекс, нийслэл, аймгаар, 2013 оны 6 дугаар сард (өмнөх сар = 100%)



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2013 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас Булган аймагт хамгийн их буюу 1.9 хувиар өсчээ. Тус аймагт үнэ өсөхөд зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны бүлгийн үнэ дүнгээрээ 23.1 хувь, хувцас, бүс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.7 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2013 оны 6 дугаар сард оны эхнээс бүх аймагт 2.7-13.0 хувиар өсчээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2013 оны 6 дугаар сард Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 0.4 хувиар буурч, харин оны эхнээс 3.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 7.6 хувиар өссөн байна.



Хэрэглээний үнийн ерөнхий индекс 2013 оны 6 дугаар сард Улаанбаатар хотод өмнөх сарынхаас буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дүн 0.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 1.2 хувь, тээврийн бүлгийнх 0.9 хувиар буурсан нь нөлөөлжээ. Түүнчлэн амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 1.3 хувиар буурсан байна. Харин согтууруулах ундаа, тамхины бүлгийн дүн 0.1 хувь, гэр ахуйн тавилга, барааных 0.6 хувь, эм, тариа эмнэлгийн үйлчилгээнийх 1.3 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 0.3 хувиар өсч, эдгээрээс бусад бараа, үйлчилгээний бүлгийн дүн өөрчлөлтгүй байв (Зураг II.6).

Улаанбаатар хотод 2013 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас хэрэглээний сагсны 329 нэрийн бараа, үйлчилгээний 8.5 хувийнх нь үнэ өсч, 10.3 хувийнх нь буурч, 81.2 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Судалгаанд сонгогдсон хүнсний 93 нэрийн барааны 17.2 хувь буюу 16 нэрийн барааны үнэ нэмэгджээ.



Зураг-II.6

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн 2013 оны 6 дугаар сарын өөрчлөлт, бүлгийн дүнгээр, хувиар



Хүснэгт-II.2

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн 2013 оны 6 дугаар сарын индекс нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт, %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	-0.6	Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн бууралтад сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 6.6 хувь, төмс, хүнсний ногооных болон жимс, жимсгэнийх тус бүр 0.6 хувь, ундаа, усных 0.2 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи	0.1	Энэ бүлгийн үнийн өсөлтөд импортын шар айрагны үнэ 1.2 хувь, оргилуун дарсных 2.3 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
Орон сууц, ус, цахилгаан, түлш	-1.2	Орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн бууралтад нэг уут нүүрсний үнэ 12.0 хувиар хямдарсан нь нөлөөлөв.
Гэр ахуйн тавилга, бараа	0.6	Энэ бүлгийн үнийн өсөлтөд орны бүтээлгийн үнэ 20.0 хувь, эдийн савангийн үнэ 4.3 хувь, угаалгын нунтаг бодисынх 1.6 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.3	Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөд хувийн эмнэлгийн ор хоногийн хөлс 5.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөллөө.
Тээвэр	-0.9	Тээврийн бүлгийн үнийн бууралтад автобензиний үнэ 3.0-3.2 хувь, дизелийн түлшнийх 2.8 хувиар хямдарсан нь нөлөөлсөн байна.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	-1.3	Энэ бүлгийн үнийн бууралтад судалгаанд сонгогдсон дижитал зургийн аппаратын үнэ 6.7 хувь, ширээний компьютерийн үнэ 5.2 хувиар хямдарсан нь нөлөөлөв.
Бусад бараа, үйлчилгээ	0.3	Бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөд эмэгтэй хүний гар цүнхний үнэ 6.1 хувиар өссөн нь нөлөөлжээ.



Орон сууцны үнийн индекс

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт орон сууцны үнийн индекс 2013 оны 2 дугаар улиралд 2010 оны эцсийнхээс 65.7 хувь, 2012 оны 2 дугаар улирлынхаас 15.7 хувь, 2012 оны эцсийнхээс 3.7 хувь, өмнөх улирлынхаас 2.9 хувиар өсчээ.


Орон сууцны үнийг дүүргээр авч үзэхэд 2013 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс Сонгинохайрхан дүүрэгт (21.2%), Баянголд (17.5%), Чингэлтэйд (14.6%), Хан-Уулд (14.4%), Баянзүрх дүүрэгт (12.7%), Сүхбаатар дүүрэгт (12.2%) өсч, 2012 оны эцсийнхээс Хан-Уулд (16.1%), Сүхбаатар дүүрэгт (14.7%), Сонгинохайрхан дүүрэгт (4.2%), Баянзүрх дүүрэгт (3.7%), Баянголд (3.6%), Чингэлтэйд (2.7%) өсч, өмнөх улирлынхаас Сонгинохайрхан дүүрэгт (4.0%), Хан-уулд (3.6%), Баянзүрх дүүрэгт (3.2%), Баянголд (2.5%), Сүхбаатар дүүрэгт (2.3%), Чингэлтэйд (2.2%) өссөн байна. (Зураг II.7).

1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнэ 2013 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс төвийн 6 дүүрэгт 8.0-22.4 хувиар нэмэгдсэн бөгөөд 1970-2001 онд ашиглалтад оруулсан орон сууцных 12.6-20.3 хувиар өсчээ. Мөн 2002 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцны үнэ төвийн 6 дүүрэгт 9.3-29.1 хувиар өссөн байна.

1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнэ 2013 оны 2 дугаар улиралд 2012 оны эцсийнхээс төвийн 6 дүүрэгт

Зураг-II.7

Улаанбаатар хотын орон сууцны үнийн индекс, хувиар, төвийн 6 дүүргээр, 2013 оны 2 дугаар улирлын байдлаар



1.7-3.8 хувиар нэмэгдсэн бөгөөд 1970-2001 онд ашиглалтад оруулсан орон сууцных 2.2-4.3 хувиар өсчээ. Мөн 2002 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцны үнэ төвийн 6 дүүрэгт 2.8-7.7 хувиар нэмэгдсэн байна.


1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнэ 2013 оны 2 дугаар улиралд өмнөх улирлынхаас төвийн 6 дүүрэгт 1.2-3.3 хувиар нэмэгдсэн бөгөөд 1970-2001 онд ашиглалтад оруулсан орон сууцных 2.2-3.9 хувиар өсчээ. Харин 2002 оноос хойш ашиглалтанд оруулсан орон сууцны үнэ төвийн 6 дүүрэгт 2.3-5.6 хувиар нэмэгдсэн байна.

Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2013 оны 6 дугаар сард үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Дундговь, Ховд, Увс, Өвөрхангай, Хөвсгөл, Говьсүмбэр аймагт хамгийн бага буюу 24.0-30.0 мян.төг; Булган, Төв, Дорнод, Хэнтий аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 39.5-45.0 мян.төг; адууны ширнийх Увс, Завхан, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ аймагт хамгийн бага буюу 20.0-25.0 мян.төг; Дорноговь, Булган, Орхон, Хэнтий, Төв аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 34.0-40.0 мян.төг; ямааны 1 кг цагаан ноолуурын үнэ Дорнод, Хэнтий, Говьсүмбэр, Сэлэнгэ, Сүхбаатар аймагт хамгийн бага буюу 40.0-53.0 мян.төг; Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Баянхонгор аймагт хамгийн их буюу 61.0-63.0

Зураг-II.8

Ямааны 1 кг цагаан ноолуурын зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 6 дугаар сард, мян.төг





мян.төг байна.

Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Орхон, Архангай, Дорнод, Завхан, Булган, Увс аймаг, Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 2.0-6.0 мян.төг буюу 4.7-25.0 хувиар өсч, Дархан-Уул, Дундговь, Сүхбаатар, Говьсүмбэр аймагт өмнөх сарынхаас 1.0-5.0 мян.төг буюу 2.6-14.3 хувиар буурч, Ховд, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймагт өмнөх сарын түвшинд байв.

Адууны ширний дундаж үнэ Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр, Булган, Төв, Орхон аймаг, Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 0.5-15.0 мян.төг буюу 1.5-75.0 хувиар өсч, Дорноговь, Дархан-Уул, Дундговь, Архангай, Завхан, Ховд, Сэлэнгэ, Увс аймагт өмнөх сарынхаас 1.0-10.0 мян.төг буюу 2.9-33.3 хувиар буурч, Баян-Өлгий, Өвөрхангай, Хөвсгөл, Дорнод аймагт өмнөх сарын түвшинд байв.

Ямааны 1 кг цагаан ноолуурын дундаж үнэ Баянхонгор, Орхон, Увс, Өмнөговь аймагт өмнөх сарынхаас 1.0-6.0 мян.төг буюу 1.6-11.5 хувиар өсч, Говь-Алтай, Завхан, Дорноговь, Ховд, Говьсүмбэр, Баян-Өлгий, Булган, Дундговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий, Архангай, Хөвсгөл, Дорнод аймаг, Улаанбаатар хотод 0.5-10.0 мян.төг буюу 0.8-20.0 хувиар буурч, Дархан-Уул, Төв, Сүхбаатар аймагт өмнөх сарын түвшинд байв.


Мал аж ахуйн зарим бүтээгдэхүүний үнийн улсын дундаж болон хамгийн өндөр байгаа аймгуудыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулж дараах зургаар харуулав.

Улаанбаатар хотод худалдаалагдсан барилгын гол нэрийн материалын дундаж үнэ


Улаанбаатар хотод 2013 оны 6 дугаар сард худалдаалагдсан эх орны үйлдвэрийн болон ОХУ, БНХАУ, БНСУ-д үйлдвэрлэсэн барилгын үндсэн 25 нэр төрлийн материалын дундаж үнийг мэдээнд хамрууллаа.

Өмнөх оны мөн үеийнхээс 2013 оны 6 дугаар сард эх орны үйлдвэрийн шалны банзны үнэ /м3/ 80.0 мян.төг буюу 53.3 хувь, захалсан банзных /м3/ 5.0 мян.төг буюу 14.3 хувь, вакуум цонхных /м2/ 5.0 мян.төг буюу 5.9 хувь, тоосгоны нэг ширхэгийн үнэ 12.5 төг буюу 4.4 хувь, хөнгөн бетоных /м3/ 2.2 мян.төг буюу 1.5 хувиар өсч 1 шуудай /50 кг/ цементнийх 575 төг буюу 6.3 хувиар буурчээ. ОХУ-д үйлдвэрлэсэн боодол хар цаасны /чулуутай/ үнэ 0.5 мян.


Зураг-II.9
Адууны 1 ширхэг ширний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 6 дугаар сард, мян.төг



Зураг-II.10
Үхрийн 2 м-ээс дээш урттай 1 ширхэг ширний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 6 дугаар сард, мян.төг



Зураг-II.11
Хонины ноостой 1 ширхэг нэхийний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 6 дугаар сард, мян.төг



төг буюу 2.3 хувь, БНХАУ-д үйлдвэрлэсэн эмульсных /дотор заслын/ 3.8 мян.төг буюу 54.3 хувь, уян шүршүүрийнх 12.5 мян.төг буюу 50.0 хувь, дүүжин таазных /м2/ 1.5 мян.төг буюу 42.9 хувь, крантных 20.0 мян.төг буюу 40.0 хувь, шалны хавтангийнх /м2/ 100 төг буюу 11.8 хувь, тосон будагных /л/ 200 төг буюу 8.7 хувь, төмөр хаалганых 10.0 мян.төг буюу 6.3 хувь, шаазан угаагуурынх 5.0 мян.төг буюу 6.3 хувь, хадаасных /кг/ 150 төг буюу 6.0 хувь, шаазан суултуурынх 5.0 мян.төг буюу



5.0 хувиар өсч, 1 шуудай /50 кг/ цементнийх 2.0 мян.төг буюу 23.5 хувь, эмульснийх /гадна заслын/ 3.7 мян.төг буюу 20.6 хувь, боодол хар цаасных /чулуугүй/ 1.0 мян төг буюу 11.1 хувь, цонхны шилнийх /нөлөөгүй, м2/ 1.0 мян. төг буюу 7.7 хувиар буурчээ.

Өмнөх сарынхаас эх орны үйлдвэрийн шалны банзны үнэ /м3/ 10.0 мян.төг буюу 4.5

хувиар өсч, 1 шуудай /50 кг/ цементнийх 0.9 мян.төг буюу 9.6 хувь, тоосгоны нэг ширхэгийн үнэ 19.5 төг буюу 6.1 хувиар буурчээ. ОХУ-д үйлдвэрлэсэн боодол хар цаасны /чулуутай/ үнэ 1.0 мян.төг буюу 4.7 хувиар өсч, БНХАУ-д үйлдвэрлэсэн 1 шуудай /50 кг/ цементнийх 1.0 мян.төг буюу 13.3 хувь, эмульсных /гадна заслын/ 1.8 мян.төг буюу 11.5 хувиар буурчээ.

II.3 Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2013 оны 6 дугаар сарын эцэст 8004.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 96.2 тэрбум төг буюу 1.2 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 952.8 тэрбум төг буюу 13.5 хувиар өсчээ (Хүснэгт II.3).

Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийн хувьд 2013 оны 6 дугаар сарын эцэст 49.2 хувийг төгрөгийн хадгаламж, 17.8 хувийг төгрөгийн харилцах, 13.8 хувийг гадаад валютын хадгаламж, 11.7 хувийг гадаад валютын харилцах, 7.5 хувийг банкнаас гадуурх мөнгө эзэлж байна (Зураг II.13). Мөнгөний нийлүүлэлтэд төгрөгийн харилцахынх 2.9 пунктээр өсч, гадаад валютын харилцахын эзлэх хувь 0.8 пункт, гадаад валютын хадгаламжийнх 1.2 пункт, банкнаас гадуурх мөнгөнийх 0.1 пункт, төгрөгийн хадгаламжийн эзлэх хувь өмнөх сарынхаас 0.7 пунктээр буурчээ.


Бага мөнгө 2013 оны 6 дугаар сарын эцэст 2026.9 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 247.7 тэрбум төг буюу 13.9 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 229.7 тэрбум төг буюу 12.8 хувиар өсчээ.

Иргэд, байгууллагын нийт хадгаламж 2013 оны 6 дугаар сарын эцэст 5040.9 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 98.1 тэрбум төг буюу 1.9 хувь буурч, өмнөх оны мөн үеийнхээс 673.3 тэрбум төг буюу 15.4 хувиар өсчээ. Төгрөгийн хадгаламж 2013 оны 6 дугаар сарын эцэст 3940.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 8.8 тэрбум төг буюу 0.2 хувь буурч, өмнөх оны мөн үеийнхээс 860.5 тэрбум төг буюу 27.9 хувиар өсөв. Гадаад валютын хадгаламж 2013 оны 6 дугаар сарын эцэст 1100.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 89.3 тэрбум төг буюу 7.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 187.2 тэрбум төг буюу 14.5 хувиар буурчээ (Хүснэгт II.3).

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2013 оны 6 дугаар сарын эцэст 835.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 4.8 тэрбум төг буюу 0.6

Зураг-II.12

Мөнгөний нийлүүлэлт (M2), хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт, сарын эцэст, хувиар, (өмнөх сар=100)




Хүснэгт-II.3

Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төг

Үзүүлэлт	2012 VI	2013 V	2013 VI
Мөнгөний нийлүүлэлт M2	7 051.2	7 907.8	8 004.0
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	22.2	17.5	13.5
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	4.8	10.1	1.2
Нийт хадгаламж	4 367.6	5 137.9	5 040.9
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	28.2	21.6	15.4
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	3.4	9.3	-1.9
Төгрөгийн хадгаламж	3 079.7	3 947.9	3 940.2
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	20.5	30.6	27.9
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	1.8	7.6	-0.2
Валютын хадгаламж	1 287.9	1 190.0	1 100.7
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	51.4	-0.9	-14.5
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	7.2	15.6	-7.5

Зураг-II.13

Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц, хувиар, жил бүрийн 6 дугаар сарын эцсийн байдлаар





хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 55.7 тэрбум төг буюу 6.2 хувиар буурчээ.

Нөөц мөнгө (M0) 2013 оны 6 дугаар сарын эцэст 3509.3 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 708.4 тэрбум төгрөгөөр өсчээ. Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох банкуудын харилцах, хадгаламж 2013 оны 6 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 703.6 тэрбум төг буюу 35.7 хувиар өсч, 2675.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Банкуудын нийт актив 2013 оны 6 дугаар сарын эцэст 14.2 их наяд төг болж, өмнөх сарынхаас 1.3 их наяд төг буюу 10.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 4.7 их наяд төг буюу 49.2 хувиар өслөө.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2013 оны 6 дугаар сарын эцэст 8607.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 381.3 тэрбум төг буюу 4.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2289.5 тэрбум төг буюу 36.2 хувиар өсчээ (Хүснэгт II.4).

Зээлийн өрийн үлдэгдлийг эзэмшигчээр нь авч үзэхэд 2013 оны 6 дугаар сарын эцэст нийт зээлийн 4727.1 тэрбум төг буюу 54.9 хувь нь хувийн секторт, иргэдэд 3811.3 тэрбум төг буюу 44.3 хувь нь, улсын байгууллагад 47.2 тэрбум төг буюу 0.6 хувь нь, бусад байгууллагад 11.2 тэрбум төг буюу 0.1 хувь, бусад санхүүгийн байгууллагад 10.9 тэрбум төг буюу 0.1 хувь нь ногдож байна.


Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2013 оны 6 дугаар сарын эцэст 316.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 1.4 тэрбум төг буюу 0.4 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 8.8 тэрбум төг буюу 2.8 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 1.2 пунктээр буурчээ (Хүснэгт II.4).

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2013 оны 6 дугаар сарын эцэст 149.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 3.3 тэрбум төг буюу 2.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 97.9 тэрбум төг буюу 2.9 дахин өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.7 хувийг эзэлж байна. (Хүснэгт II.4).

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2013 оны 5 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 0.6 пунктээр буурч, өмнөх

Зураг-II.14

Мөнгөний нийлүүлэлт (M2), бага мөнгө (M1) болон бараг мөнгөний өөрчлөлт, сарын эцэст, хувиар, (өмнөх оны мөн үе=100)



Эх үүсвэр: * Монголбанкны статистикийн сарын бюллетень


Хүснэгт-II.4

Зээлийн өрийн үлдэгдэл, чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл, сарын эцэст, тэрбум төг

Үзүүлэлт	2012 VI	2013 V	2013 VI
Зээлийн өрийн үлдэгдэл	6 318.2	8 226.4	8 607.7
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	38.8	34.4	36.2
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	3.2	5.9	4.6
Чанаргүй зээл	307.8	318.0	316.6
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 21.2	0.7	2.8
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 2.5	2.3	- 0.4
Хугацаа хэтэрсэн зээл	51.8	146.4	149.7
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 25.9	143.8	189.1
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 13.8	32.0	2.3
Зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.9	3.9	3.7
Зээлийн өрийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь	0.8	1.8	1.7

Зураг-II.15

Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төг





оны мөн үеийнхээс 0.6 пунктээр өсч, жилийн хүү 18.5 хувь болжээ. Валютын зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сарын хэмжээнд байж, харин өмнөх оны мөн үеийнхээс 0.3 пунктээр өсч, жилийн хүү 13.2 хувь боллоо (Зураг II.16).

Гадаад валютын цэвэр албан нөөц 2013 оны 6 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 288.3 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеийнхээс 128.0 сая ам.доллараар буурч, 2590.1 сая ам.долл болсон нь манай улсын импортын 21.8 долоо хоног буюу 5.5 сарын хэрэгцээг хангахаар байна (Зураг II.17).

Үнэт цаасны зах зээл

Үнэт цаасны арилжаагаар 2013 оны эхний 6 сард 12.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 22.0 сая ш үнэт цаас арилжигдсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс үнэт цаасны гүйлгээ 48.6 тэрбум төг буюу 79.8 хувь, арилжигдсан үнэт цаасны тоо 86.2 сая ш буюу 79.7 хувиар буурчээ.


Үнэт цаасны арилжаа 2013 оны 6 дугаар сард 19 өдөр явагдаж, 0.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 1.8 сая ш үнэт цаас арилжигдсан байна. Гүйлгээний хэмжээ 2013 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 129.9 сая төг буюу 12.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 41.2 тэрбум төг буюу 97.8 хувиар буурчээ. Арилжсан үнэт цаасны тоо 2013 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 115 мян.ш буюу 6.9 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 64.1 сая ш буюу 97.3 хувиар буурлаа.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2013 оны 6 дугаар сард 14451.5 болж, өмнөх сарынхаас 832.3 нэгжээр өсчээ (Зураг II.18). Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2013 оны 6 дугаар сард 1437.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 63.9 тэрбум төг буюу 4.7 хувиар өсчээ (Зураг II.19).

“РЕМИКОН” хувьцаат компаний 529.6 мян.ш хувьцаа 2013 оны 6 дугаар сард арилжигдсан нь хамгийн идэвхтэй арилжаалсан үнэт цаас байв.


Зураг-II.16

Зээлийн жилийн хүү, сарын эцэст, хувиар




Зураг-II.17

Гадаад валютын цэвэр албан нөөц, сарын эцэст, сая ам.долл




Зураг-II.18

ТОП-20 индекс, сарын дундаж, хувиар



Зураг-II.19

Зах зээлийн үнэлгээ, сарын эцэст, тэрбум төг





Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2013 оны 6 дугаар сард 1437.8 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 109.8 төг буюу 8.3 хувиар суларсан байна (Хүснэгт II.5). Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2013 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 1.5 хувь суларч, 2013 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 0.03 хувиар чангарчээ (Зураг II.20).

Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2013 оны 6 дугаар сард 1898.6 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 231.8 төг буюу 13.9 хувиар суларчээ (Хүснэгт II.5). Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2013 оны 5 дугаар сард 1.3 хувь, 6 дугаар сард өмнөх сарынхаас 1.6 хувиар суларсан байна (Зураг II.21).

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2013 оны 6 дугаар сард 234.4 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 25.7 төг буюу 12.3 хувиар суларчээ (Хүснэгт II.5). Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2013 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 2.2 хувь, 2013 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 0.1 хувиар суларсан байна (Зураг II.22).

Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2013 оны 6 дугаар сард 44.5 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 4.0 төг буюу 9.9 хувиар суларчээ (Хүснэгт II.5). Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2013 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 1.5 хувиар суларч, 2013 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 3.1 хувиар чангарсан байна (Зураг II.23).


Хүснэгт-II.5

Монголбанкны төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг

Үзүүлэлт	2012 V	2013 IV	2013 V
Ам. доллар	1 318.0	1 417.4	1 438.3
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	6.7	7.9	9.1
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	0.4	0.9	1.5
Евро	1 689.8	1 843.7	1 867.9
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 5.0	6.7	10.5
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 2.2	1.3	1.3
Юань	208.4	229.1	234.2
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	9.5	10.0	12.4
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	0.1	1.4	2.2
Рубль	42.8	45.2	45.9
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 3.6	1.6	7.2
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 3.8	- 0.8	1.5


Зураг-II.20

Төгрөгийн ам. доллартай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг




Зураг-II.21

Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг




Зураг-II.22

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг



Зураг-II.23

Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг





II.4 Улсын нэгдсэн төсөв

Зураг-II.24

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2013 оны эхний хагас жилд 2504.9 тэрбум төг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2637.9 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 133.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Өмнөх оны мөн үеийнхээс улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 441.6 тэрбум төгрөгөөр буурахад орлогын өсөлт нь зарлагын өсөлтөөс 16.3 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ (Зураг-II.24).

Улсын нэгдсэн төсвийн урсгал орлого 2504.5 тэрбум төг, урсгал зардал 2353.8 тэрбум төг болж, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 150.7 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Өмнөх оны мөн үеийнхээс нэгдсэн төсвийн урсгал орлого 156.7 тэрбум төг, урсгал зардал 71.4 тэрбум төгрөгөөр өсчээ.


Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2013 оны 5 дугаар сард 422.1 тэрбум төг байсан бол 2013 оны 6 дугаар сард 493.5 тэрбум төг болж өмнөх сарынхаас 71.5 тэрбум төг буюу 16.9 хувиар өсчээ. Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2013 оны 5 дугаар сард 418.7 тэрбум төг байсан бол 2013 оны 6 дугаар сард 765.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 347.1 тэрбум төг буюу 82.9 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2013 оны 5 дугаар сард 3.3 тэрбум төгрөгийн ашигтай, 2013 оны 6 дугаар сард 272.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Төсвийн орлого

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2013 оны эхний хагас жилд 2504.9 тэрбум төг, тогтворжуулалтын санд 32.7 тэрбум төг нийтдээ 2537.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 156.7 тэрбум төг буюу 6.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны мөн үеийнхээс татварын нийт орлого 66.2 тэрбум төг буюу 3.1 хувиар нэмэгдэхэд бусад татварын орлого 209.9 тэрбум төг буюу 43.4 хувиар буурсан хэдий ч дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 115.0 тэрбум төг буюу 15.6 хувь, орлогын албан татварын орлого 87.5 тэрбум

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, тэрбум төг



төг буюу 21.9 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 71.8 тэрбум төг буюу 22.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Өмнөх оны мөн үеийнхээс татварын бус орлого 90.5 тэрбум төг буюу 37.4 хувиар өсөхөд хувьцааны ногдол ашгийн орлого 19.9 тэрбум төг буюу 82.2 хувь, бусад нэр заагдаагүй орлого 4.6 тэрбум төг буюу 14.2 хувиар буурсан хэдий ч хүү, торгуулийн орлого 53.0 тэрбум төг буюу 2.8 дахин, газрын тосны орлого 31.4 тэрбум төг буюу 2 дахин, төсөвт газрын өөрийн орлого 25.5 тэрбум төг буюу 24.4 хувь, навигацын орлого 4.7 тэрбум төг буюу 24.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 85.6 хувийг татварын орлого, 13.1 хувийг татварын бус орлого, 1.3 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс татварын орлогын эзлэх хувь 2.9 пункт, хөрөнгийн орлогынх 0.2 пунктээр буурч, татварын бус орлогынх 2.9 пункт, тогтворжуулалтын сангийн орлогынх 0.2 пунктээр өсчээ (Хавсралт 5).

Төсвийн зарлага

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2013



оны эхний хагас жилд 2637.9 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 292.2 тэрбум төг буюу 10.0 хувиар буурсан нь бараа, үйлчилгээний зардал 347.4 тэрбум төг буюу 37.1 хувь, зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 37.0 тэрбум төг буюу 67.0 хувиар өссөн хэдий ч хөрөнгийн зардал 353.6 тэрбум төг буюу 58.3 хувь, татаас ба шилжүүлгийн зардал 313.0 тэрбум төг буюу 24.2 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 10.0 тэрбум төг буюу 24.2

хувиар буурснаас шалтгаалжээ.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 89.2 хувь, хөрөнгийн зардал 9.6 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 1.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс хөрөнгийн зардлын эзлэх хувь 11.1 пункт, эргэж төлөгдөх цэвэр зээлийнх 0.2 пунктээр буурч, урсгал зардлынх 11.3 пунктээр өсчээ (Хавсралт 5).

II.5 Гадаад худалдаа

Зураг-II.25

Монгол Улс 2013 оны эхний хагас жилд дэлхийн 120 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 5094.5 сая ам.долл, үүнээс экспорт 2023.7 сая ам.долл, импорт 3070.7 сая ам.долларт хүрчээ (Зураг I.25). Өмнөх оны мөн үеийнхээс нийт бараа эргэлтийн хэмжээ 472.0 сая ам.долл буюу 8.5 хувь, үүний дотор импортын хэмжээ 242.5 сая ам.долл буюу 7.3 хувь, экспортын хэмжээ 229.4 сая ам.долл буюу 10.2 хувиар буурчээ.

Өмнөх оны эхний хагас жилд гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 54.2 хувь нь БНХАУ-д, 16.7 хувь нь ОХУ-д, 29.1 хувь нь бусад улсад ногдож байсан бол 2013 оны эхний хагас жилд нийт бараа эргэлтийн 50.4 хувь нь БНХАУ, 14.7 хувь нь ОХУ, 34.9 хувь нь бусад улсад ногдож байна. Өмнөх оны мөн үеийнхээс БНХАУ-тай хийсэн худалдааны эзлэх хувь 3.8 пункт, ОХУ-ынх 2.0 пунктээр буурсан бол бусад улсынх 5.8 пунктээр өсчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2013 оны эхний хагас жилд 1.0 тэрбум ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 13.1 сая ам.долл буюу 1.2 хувиар буурчээ.


Гадаад худалдааны тэнцэл 2012 оны 6 дугаар сард 111.1 сая ам.долларын алдагдалтай гарсан бол 2013 оны 6 дугаар сард 222.2 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 111.1 сая ам.долл буюу 2.0 дахин нэмэгдсэн байна.

Экспорт

Манай улс 2013 оны эхний хагас жилд нийт 49 оронд бараа, бүтээгдэхүүн экспортолсноос БНХАУ-д 88.0 хувь, Канад улсад 3.7 хувь, Их Британи улсад 3.6 хувь, ОХУ-д 1.4 хувь ногдож байгаа нь нийт экспортын 96.7 хувийг эзэлж байна (Зураг II.26).


Экспортын 97.4 хувийг эрдэс бүтээгдэхүүн,

Гадаад худалдааны нийт бараа эргэлт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, сая ам.долл



Зураг-II.26

Экспортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2013 оны эхний хагас жилийн байдлаар



Хүснэгт-II.6

Экспортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, хувиар

	2011 I-VI	2012 I-VI	2013 I-VI
Эрдэс бүтээгдэхүүн	85.6	90.2	80.7
Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	7.3	5.6	8.6
Үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	3.3	2.0	6.7
Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	1.5	0.7	0.9
Авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	0.3	0.2	0.5
Бусад	2.0	1.3	2.6



нэхмэл бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги эзэлж байна (Хүснэгт II.7).

Экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 229.4 сая ам.долл буюу 10.2 хувиар буурахад экспортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг эрдэс бүтээгдэхүүний экспорт 398.1 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Экспортын дүнд нүүрс 26.8 хувь, зэсийн баяжмал 20.0 хувь, төмрийн хүдэр 17.3 хувь, боловсруулаагүй газрын тос 10.0 хувь, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 6.7 хувь, цайрын хүдэр, баяжмал 3.7 хувь, жоншны хүдэр, баяжмал 1.8 хувь, бусад бүтээгдэхүүн 13.7 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеийнхээс нийт экспортод төмрийн хүдрийн эзлэх хувь 6.4 пункт, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтных 4.7 пункт, боловсруулаагүй газрын тос 3.3 пункт, цайрын хүдэр, баяжмалынх 1.2 пункт, зэсийн баяжмалынх 1.3 пунктээр өсч, нүүрснийх 21.5 пункт, жоншны хүдэр, баяжмалынх 0.2 пунктээр буурчээ.

Импорт

Манай улс 2013 оны эхний хагас жилд нийт 118 оронтой импортын худалдаа хийсний 25.6 хувийг БНХАУ-тай, 23.5 хувийг ОХУ-тай, 11.6 хувийг АНУ-тай, 7.8 хувийг Япон улстай, 7.6 хувийг БНСУ-тай, 3.5 хувийг Беларусь улстай, ХБНГУ-тай 3.2 хувийг хийсэн нь нийт дүнгийн 82.8 хувийг эзэлж байна (Зураг II.24). Импортын нийт хэмжээнд зарим орнуудын эзлэх хувийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад АНУ-ынх 1.9 пункт, Беларусь улсынх 2.1 пункт, БНСУ-ынх 0.8 пунктээр өсч, ОХУ-ынх 3.5 пункт, БНХАУ-ынх 1.3 пункт, ХБНГУ-ынх 0.2 пунктээр буурчээ.

Импортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 242.5 сая ам.долл буюу 7.3 хувиар буурахад машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 160.9 сая ам.долл, авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүнийх тус бүр 47.7 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлөв.

Нийт импортод эрдэс бүтээгдэхүүн 25.2 хувь, машин, механик төхөөрөмж, цахилгаан


Хүснэгт-II.7

Экспортолсон зарим эрдэс бүтээгдэхүүн, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, мян.т

	2011 I-VI	2012 I-VI	2013 I-VI
Нүүрс	7 743.6	10 301.6	7 483.9
Зэсийн баяжмал	284.2	285.5	282.8
Төмрийн хүдэр	2 544.9	3 180.4	3 197.3
Боловсруулаагүй газрын тос (мян. баррел)	1 073.9	1 533.5	2 138.4
Цайрын хүдэр, баяжмал	64.1	57.6	77.5
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт (т)	1.6	1.0	3.2


Зураг-II.27

Импортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2013 оны эхний хагас жилийн байдлаар



Зураг-II.28

Импортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, хувиар



хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг 22.2 хувь, авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 21.8 хувь, үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүн 7.4 хувь, хүнсний бэлэн бүтээгдэхүүн 5.9 хувийг эзэлж, үлдсэн 17.5 хувийг бусад бүлгийн бүтээгдэхүүн эзэлж байна (Зураг II.28).



Өмнөх оны мөн үеийнхээс 2013 оны эхний хагас жилд импортолсон цахилгаан эрчим хүчний биет хэмжээ 224.5 сая квт.ц, үнийн дүн 23.3 сая ам.долл, автобензиний биет хэмжээ 13.9 мян.т, үнийн дүн 12.8 сая ам.долл, суудлын автомашины биет хэмжээ 551 ширхэгээр өсч, харин үнийн дүн нь 32.8 сая ам.доллараар, гурилын биет хэмжээ 26.6 мян.т, үнийн дүн 6.3 сая ам.доллараар буурчээ. (Зураг II.29).

Газрын тосны бүтээгдэхүүний импорт 2013 оны эхний хагас жилд 543.5 мян.т буюу 650.0 сая ам.долл болж, нийт импортын үнийн дүнгийн 21.2 хувийг эзэлж, биет хэмжээ нь өмнөх оны мөн үеийнхээс 16.5 мян.т буюу 3.1 хувиар өссөн байна.


Газрын тосны бүтээгдэхүүнийг ОХУ, Беларусь, БНСУ-аас; гурилыг ОХУ болон Казахстан улсаас; элсэн чихрийг Тайланд, Малайз улсаас; нийтийн тээврийн хэрэгслийг БНСУ, БНХАУ-аас; суудлын автомашиныг Япон, БНСУ, ХБНГУ, АНУ, Их Британи улсаас; ачааны автомашиныг АНУ, БНХАУ, БНСУ, Япон улсаас голлон авсан байна.

II.6 Бизнес регистрийн сан

Аж ахуйн нэгж, байгууллагын регистрийн санд 2013 оны эхний хагас жилд 94.0 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 51.3 мянга буюу 54.6 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 31.6 мянга буюу 61.6 хувь нь Улаанбаатар хотод, 6.8 мянга буюу 13.2 хувь нь Төвийн бүс, 5.6 мянга буюу 11.0 хувь нь Хангайн бүс, 5.2 мянга буюу 10.0 хувь нь Баруун бүс, 2.1 мянга буюу 4.2 хувь нь Зүүн бүсэд ногдож байна.

Регистрийн санд 2013 оны эхний хагас жилд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулаагүй

Зураг-II.29
Зарим барааны импорт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, мян.ам.долл



Импортолсон барааны 92.2 хувийг валютын төлбөртэй худалдаа, 6.4 хувийг гадаадын хөрөнгө оруулалтын бараа, 1.2 хувийг тусламжийн бараа, 0.2 хувийг зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа эзэлж байна.

42.7 мянган аж ахуйн нэгж, байгууллага байгаагийн 12.1 мянга буюу 28.4 хувь нь үйл ажиллагаагаа эхлээгүй, 23.2 мянга буюу 54.3 хувь нь түр зогссон, 0.7 мянга буюу 1.7 хувь нь бүрэн зогссон, 6.7 мянга буюу 15.6 хувь нь хаяг тодорхойгүй буюу олдохгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 83.5 хувь нь 1-9 ажиллагчидтай, 7.3 хувь нь 10-19 ажиллагчидтай, 5.7 хувь нь 20-49 ажиллагчидтай, 3.5 хувь нь 50-иас дээш ажиллагчидтай байна.



III. Үйлдвэрлэл, үйлчилгээ

Зураг-III.1

III.1 Мал аж ахуй

Улсын хэмжээнд 2012 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 17.7 сая хээлтэгч малын 85.6 хувь буюу 15.2 сая хээлтэгч 2013 оны эхний хагас жилд төллөсөн байна. Эм хонины 88.4 хувь, эм ямааны 86.5 хувь, ингэний 44.0 хувь, үнээний 72.7 хувь, гүүний 68.8 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 97.9 хувь буюу 14942.4 мян.толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1615.1 мянга буюу 12.1 хувиар илүү байна (Хавсралт ...).

Унага бойжилт 97.7 хувь, тугал 98.0 хувь, ботго 98.2 хувь, хурга 98.2 хувь, ишиг 97.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс тугал, хурга, ишиг 0.1-0.6 пунктээр буурч, унага, ботго 0.1 пунктээр өссөн байна (Зураг III.1, Хавсралт ...).

Том малын зүй бус хорогдол 2013 оны эхний хагас жилд, улсын хэмжээнд 638.4 мян. толгойд хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 362.8 мян.толгой буюу 2.3 дахин нэмэгдсэн байна. Том малын зүй бус хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 29.5 мянга, үхэр 63.1 мянга, тэмээ 0.9 мянга, хонь 278.0 мянга, ямаа 267.0 мянга байна (Зураг III.4). Нийт хорогдлын 43.5 хувийг хонь, 41.8 хувийг ямаа эзэлж байна.

Архангай аймагт оны эхэнд тоологдсон малын 5.5 хувь буюу 187.8 мянга, Хөвсгөл аймагт 2.3 хувь буюу 84.6 мянга, Завхан аймагт 2.5 хувь буюу 55.9 мянга, Баянхонгор аймагт 2.0 хувь буюу 52.2 мянга, Дорнод аймагт 3.6 хувь буюу 43.6 мянга, Говь-Алтай аймагт 1.6 хувь буюу 31.3 мянга, Төв аймагт 1.0 хувь буюу 31.0 мянга, Булган аймагт 1.1 хувь буюу 27.5 мянга нь 2013 оны эхний хагас жилд, хорогдлоо. Улсын хэмжээнд хорогдсон малын 80.5 хувийг эдгээр аймагт хорогдсон мал эзэлж байна (Зураг III.3).


Улсын хэмжээнд 2013 оны эхний хагас жилд 64.2 мян.мал өвчнөөр хорогдсон нь өмнөх оны мөн үеийнхээс 47.2 мянга буюу 277.6 хувиар өсчээ.

Төллөсөн хээлтэгч, аймаг, нийслэлээр, 2013 оны эхний хагас жилд, мян.толгой



Зураг-III.2

Бойжуулсан төл, төрлөөр, жил бүрийн эхний хагас жилд, мян.толгой






Зураг-II.3

Зүй бусаар хорогдсон том мал, аймаг, нийслэлээр 2013 оны эхний хагас жилд, мян.толгой



Зураг-III.4

Зүй бусаар хорогдсон том мал, аймаг, нийслэлээр 2013 оны эхний 5 сард, мян.толгой




Газар тариалан

Улсын хэмжээнд 2013 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар 410.0 мян.га талбайд тариалалт хийснээс үр тариа 288.9 мян.га-д, төмс 15.3 мян.га-д, хүнсний ногоо 8.2 мян.га-д, тэжээлийн ургамал 11.2 мян.га-д, техникийн ургамал 82.4 мян.га-д бусад ургамал 4.0 мян.га-д тариалсан байна.

Нийт тариалсан талбай өмнөх оны мөн үеийнхээс 36.4 мян.га буюу 9.7 хувиар их байгаагаас үр тарианых 16.7 мян.га буюу 5.5 хувиар, төмснийх 785.4 га буюу 4.9 хувиар, тэжээлийн ургамлынх 527.6 га буюу 4.5 хувиар буурч, харин хүнсний ногооных 501.5 га буюу 6.5 хувь, техникийн ургамлынх 49.9 мян.га буюу 2.5 дахин нэмэгдсэн байна (Зураг III.6).

Зураг-III.5

Тариалсан талбай, жил бүрийн 7 дугаар сарын 1-ний байдлаар, мян.га





III.2 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр, 2013 оны эхний хагас жилд 1104.8 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 59.1 тэрбум төг буюу 5.7 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын зэсийн баяжмал, газрын тос, алт зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 12.8-76.1 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарын амтат ус ундаа, шар айраг, ган төмөр хийц, хиаман төрлийн бүтээгдэхүүн, зүсмэл материал, хивс, гурил, барилгын модон хаалга, цонх, самнасан ноолуур, бетон зуурмаг, савласан ногоон цай зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.1 хувиас 6.5 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын буталмал чулуу, цайрын баяжмал, молибдений баяжмал, нүүрс, төмрийн хүдэр, хайлуур жоншны баяжмал зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.4-57.0 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарын катодын зэс, архи, малын мах, металл бэлдэц, бетон дэр, тамхи, цемент, цахилгааны утас зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.6-92.3 хувиар буурсан байна.


Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр, 2013 оны эхний хагас жилд 2865.2 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 201.4 тэрбум төг буюу 7.6 хувиар, үүнээс боловсруулах аж үйлдвэрийнх 184.8 тэрбум төг буюу 30.6 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 22.8 тэрбум төг буюу 9.5 хувиар өсч, харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 6.2 тэрбум төг буюу 0.3 хувиар буурчээ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн оны үнээр, 2013 оны эхний хагас жилд 2833.5 тэрбум төг болж, 1695.7 тэрбум төг буюу 59.8 хувийг гадаад зах зээлд борлуулжээ (Хавсралт 14).

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүний 55.1 хувь нь уул уурхай, олборлох аж үйлдвэрт, 35.7 хувь нь боловсруулах аж үйлдвэрт, 9.2 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт ногдож байна (Зураг III.3). Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 2013 оны эхний хагас жилд 1558.5 тэрбум төг болж, 1259.8 тэрбум төг буюу 80.8 хувийг,


Зураг-III.6

Уул уурхайн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өөрчлөлт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, хувиар, 2005=100%




Зураг-III.7

Түлш, эрчим хүчний гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өөрчлөлт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, хувиар, 2005=100%



Зураг-III.8

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, хувиар





боловсруулах аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 1012.9 тэрбум төг болж, 435.8 тэрбум төг буюу 43.0 хувийг нь гадаад зах зээлд борлуулав.

Нийт борлуулалтад боловсруулах аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2013 оны эхний хагас жилд 35.7 болж, өмнөх оны мөн үеийнхээс 4.3 пункт, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 9.2 хувь болж 0.9 пунктээр нэмэгдэж, харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 55.1 хувь болж 5.2 пунктээр буурлаа (Зураг III.3).

Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо 2013 оны 6 дугаар сарын эцэст 65394 болж, өмнөх оны мөн үеийнхээс 7156 хүн буюу 12.3 хувиар өсчээ. Ажиллагчдын тоо уул уурхай, олборлох

аж үйлдвэрийн салбарт 3803 хүн буюу 20.0 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 3134 хүн буюу 12.0 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 219 хүн буюу 1.7 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 2013 оны эхний 6 сард 18480.2 мян.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 313.1 мян.төг буюу 1.7 хувиар буурчээ. Хөдөлмөрийн бүтээмж цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 528.7 мян.төг буюу 6.1 хувиар өсч, харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 1824.3 мян.төг буюу 5.3 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 258.0 мян.төг буюу 1.9 хувь буурлаа.

III.3 Барилга

Барилгын байгууллагууд 2013 оны эхний хагас жилд нийт 355.2 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 338.5 тэрбум төг буюу 95.3 хувь нь дотоодын, 16.7 тэрбум төг буюу 4.7 хувь нь гадаадын барилгын байгууллагуудад ногдож байна.

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 214.6 тэрбум төг буюу 2.5 дахин, үүнээс дотоодын байгууллагынх 199.6 тэрбум төг буюу 2.4 дахин, гадаадын байгууллагынх 15.0 тэрбум төг буюу 9.5 дахин өсчээ.

Барилга угсралт, их засварын ажлын 4.5 хувь нь их засварын ажил, 30.5 хувь нь орон сууцны барилга, 30.5 хувь нь орон сууцны бус барилга, 34.5 хувь нь инженерийн барилга, байгууламжид ногдож байна. Өмнөх оны мөн үеийнхээс орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 3.7 пункт, инженерийн барилга, байгууламж 14.3 пунктээр нэмэгдэж, орон сууцны бус барилга 12.1 пункт, их засвар 5.8 пунктээр буурлаа.

Хүснэгт-III.1
Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ, оны үнээр

Гүйцэтгэгчийн төрөл	2011 I-VI	2012 I-VI	2013 I-VI	2013 I-VI / 2012 I-VI %
Барилга угсралт, их засварын ажил, бүгд	97 498.5	140 609.9	355 219.1	252.6
- Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн	95 532.0	138 850.2	338 462.4	243.8
- Гадаадын барилгын байгууллагын гүйцэтгэсэн	1 966.4	1 759.7	16 756.7	952.3

Зураг-III.9
Барилга угсралт, их засварын ажил, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, тэрбум төг





III.4 Тээвэр, холбоо

Шуудан холбоо

Шуудан, холбооны үйлчилгээний орлого 2013 оны эхний хагас жилд 278.6 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 22.0 тэрбум төг буюу 8.6 хувиар өсчээ. Нийт орлогод хүн амаас орсон орлого 74.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 2.4 пунктээр буурсан байна.

Суурин утасны цэгийн тоо 2013 оны эхний хагас жилд 159.8 мян.ш болж, өмнөх оны мөн үеийнхээс 25.3 мян.ш буюу 18.8 хувиар өсчээ.

Энэ оны эхний хагас жилд үүрэн утас хэрэглэгчдийн тоо давхардсан дүнгээр 3524.7

мянга, кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо 262.4 мянгад хүрчээ. Өмнөх оны мөн үеийнхээс үүрэн утас хэрэглэгчдийн тоо 124.5 мянга буюу 3.7 хувь, кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо 68.5 мянга буюу 35.3 хувиар нэмэгджээ.

Шуудангийн үйлчилгээний салбар 2013 оны эхний хагас жилд 331.0 мян.ш бичиг, захидал, 63.0 мян.ш илгээмж, 6392.6 мян.ш тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэсэн байна. Хүргэсэн бичиг, захидал өмнөх оны мөн үеийнхээс 10.5 мян.ш буюу 3.3 хувь, илгээмж 0.3 мян.ш буюу 0.5 хувиар нэмэгдэж, харин хүргэсэн тогтмол хэвлэл 2968.7 мян.ш буюу 31.7 хувиар буурсан байна.

Хүснэгт-III.2

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ, оны үнээр

Гүйцэтгэгчийн төрөл	2011 I-VI	2012 I-VI	2013 I-VI	2013 I-VI / 2012 I-VI %
Нийт орлого, оны үнээр, сая төг	213 010.5	256 617.7	278 620.7	108.6
Хүн амаас орсон орлого, сая төг	157 952.0	198 221.0	208 419.8	105.1
Суурин утасны цэг, мян.ш	135.1	134.5	159.8	118.8
Утасгүй холбооны тоо*	5 171	4 852	3 593	74.1
Үүрэн утас хэрэглэгчдийн тоо, мян.хүн (давхардсан тоогоор)	2 712.7	3 400.2	3 524.7	103.7
Кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо	120 087	193 929	262 445	135.3
Шуудангийн үйлчилгээний үзүүлэлт				
Хүргэсэн бичиг, захидал, мян.ш	332.0	320.5	331.0	103.3
Хүргэсэн илгээмж, мян.ш	58.1	62.7	63.0	100.5
Хүргэсэн хэвлэл, мян.ш	6 702.6	9 361.3	6 392.6	68.3

* Утасгүй холбооны дүнгээс МЦХ ХХК-ны дүнг хасаж тооцсон.

Тээвэр


Бүх төрлийн тээврээр 2013 оны эхний хагас жилд 19.0 сая т ачаа, давхардсан тоогоор 181.3 сая зорчигч тээвэрлэж, өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 1.4 сая т буюу 6.9 хувиар буурч, харин зорчигчдын тоо 31.6 сая хүн буюу 21.1 хувиар өсчээ.

Авто тээврээр тээсэн ачаа 2013 оны эхний хагас жилд 9.0 сая т болж, өмнөх оны мөн үеийнхээс 1.6 сая т буюу 15.0 хувиар буурчээ. Энэ оны эхний хагас жилд давхардсан тоогоор 179.1 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс 31.6 сая зорчигч буюу 21.4 хувиар өсчээ. Авто тээврийн орлого өмнөх оны мөн үеийнхээс 37.6 тэрбум төг буюу 39.9 хувиар нэмэгдсэн байна.

Төмөр замын тээврээр 2013 оны эхний хагас жилд 10066.3 мян.т ачаа, давхардсан тоогоор 1886.9 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 174.1 мян.т буюу 1.8 хувиар өсч, зорчигчдын тоо 72.9 мян.хүн буюу 3.7 хувиар буурсан байна (Зураг III.10.а, III.10.б).


Зураг-III.10а

Төмөр замын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, мян.хүн



Зураг-III.10б

Төмөр замын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, мян.т





Хүснэгт-III.3

Төмөр замаар тээвэрлэсэн нийт ачааны хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс өсөхөд экспортын ачааны тээвэрлэлт 482.1 мян.т буюу 14.2 хувиар буурсан хэдий ч дотоодод тээвэрлэсэн ачаа 566.9 мян.т буюу 12.3 хувь, импортын ачаа 17.5 мян.т буюу 1.6 хувь, дамжин өнгөрсөн ачаа 71.9 мян.т буюу 9.3 хувиар өссөн нь нөлөөлөв.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2013 оны 6 дугаар сард 1852.6 мян.т болж, өмнөх сарынхаас 18.0 мян.т буюу 1.0 хувиар буурч, орлого 40.0 тэрбум төг болж, 2.1 тэрбум төг буюу 5.7 хувь, зорчигчдын тоо 352.3 мян.хүн болж, 30.8 мян.хүн буюу 9.6 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс тээврийн орлого 5.6 тэрбум төг буюу 16.2 хувь, тээсэн ачаа 347.5 мян.т буюу 23.1 хувиар өсч, зорчигчдын тоо 7.7 мян. хүн буюу 2.1 хувиар буурчээ.

Төмөр замын тээврийн салбарын орлого 2013 оны эхний хагас жилд 201.4 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 5.3 тэрбум төг буюу 2.6 хувиар буурчээ (Хүснэгт III.3).

Агаарын тээврээр 2013 оны эхний хагас жилд 1916.9 т ачаа, давхардсан тоогоор 346.1 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 40.5 т буюу 2.2 хувь, зорчигчдын тоо 24.8 мян.хүн буюу 7.7 хувиар өслөө.

Агаарын тээврийн орлого 2013 оны 6 дугаар сард 20.9 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 4.7 тэрбум төг буюу 29.3 хувь, зорчигчдын тоо 71.7 мян.хүн болж 14.5 мян.хүн буюу 25.4 хувь, тээсэн ачаа 422.7 т болж 80.1 т буюу 23.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс тээврийн орлого 2.4 тэрбум төг буюу 13.0 хувь, зорчигчдын тоо 6.8 мян.хүн буюу 10.5 хувь, тээсэн ачаа 30.1 т буюу 7.6 хувиар өсчээ (Зураг III.19.а, III.19.б).

Агаарын тээврээр дотоодод зорчсон зорчигчдын тоо өмнөх оны мөн үеийнхээс 32.2 мян.хүн буюу 25.8 хувиар өсч, олон улсад зорчсон зорчигчдын тоо 7.5 мян.хүн буюу 3.8 хувиар буурав.


Агаарын тээврийн салбарын орлого 2013 оны эхний хагас жилд 96.6 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 8.2 тэрбум төг буюу 9.3 хувиар өслөө (Хүснэгт III.4).

Төмөр замын тээврийн орлого, тээсэн ачаа болон зорчигчдын тоо, сараар

Хугацаа, сараар	Тээврийн орлого, сая төг	Зорчигч тээвэрлэлт, мян.хүн	Тээсэн ачаа, мян.т
2011 I	24 937.1	293.0	1 345.0
II	21 280.4	279.7	1 244.0
III	27 989.6	281.1	1 436.8
IV	32 225.5	301.1	1 494.0
V	33 386.3	324.6	1 489.1
VI	34 575.4	341.6	1 515.9
2011 I-VI	174 394.1	1 821.0	8 524.8
2012 I	36 061.9	297.1	1 715.7
II	31 891.7	320.7	1 604.6
III	32 669.4	298.2	1 630.6
IV	34 807.8	348.4	1 666.7
V	36 822.2	335.3	1 769.5
VI	34 443.5	360.0	1 505.1
2012 I-VI	206 696.6	1 959.8	9 892.2
2013 I	31 880.0	315.8	1 664.2
II	21 200.2	293.7	1 321.0
III	34 448.8	280.3	1 616.6
IV	35 996.2	323.4	1 741.3
V	37 866.0	321.5	1 870.6
VI	40 013.2	352.3	1 852.6
2013 I-VI	201 404.4	1 886.9	10 066.3
2013 I-VI % 2012 I-VI	97.4	96.3	101.8
2013 VI % 2012 VI	116.2	97.9	123.1
2013 VI % 2013 V	105.7	109.6	99.0


Зураг-III.10а

Агаарын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, мян.хүн



Зураг-III.10б

Агаарын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, т





Хүснэгт-III.4

Агаарын тээврийн орлого, зорчигчдын тоо болон тээсэн ачаа, сараар

Он	Тээврийн орлого, сая төг	Зорчигч тээвэрлэлт, мян.хүн	Тээсэн ачаа, т
2011 I	9 021.4	36.5	128.6
II	9 021.2	29.2	123.5
III	8 204.8	35.0	152.1
IV	9 825.9	37.3	153.1
V	10 220.4	41.5	142.8
VI	16 462.4	54.8	259.1
2011 I-VI	62 756.1	234.3	959.2
2012 I	14 207.7	46.2	302.3
II	12 655.0	47.8	257.8
III	14 175.8	53.3	315.2
IV	13 697.7	52.3	304.5
V	15 125.9	56.7	303.8
VI	18 538.7	64.9	392.6
2012 I-VI	88 400.8	321.3	1 876.3
2013 I	17 385.6	59.2	290.6
II	12 911.4	48.8	236.6
III	15 310.2	56.2	322.5
IV	13 834.7	53.0	302.0
V	16 194.6	57.2	342.5
VI	20 942.5	71.7	422.7
2013 I-VI	96 579.2	346.1	1 916.9
2013 I-VI / 2012 I-VI %	109.3	107.7	102.2
2013 VI / 2012 VI %	113.0	110.5	107.6
2013 VI / 2013 V %	129.3	125.4	123.4

харьцуулахад Энэтхэг улсын жуулчдын тоо 18.6 хувиар, ХБНГУ-ынх 17.8 хувиар өссөн бол БНХАУ-ын жуулчдын тоо 25.3 хувиар буурчээ. Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 79.6 хувь буюу 172.9 мянга нь эрэгтэйчүүд байна.


Улсын хилээр 2013 оны эхний хагас жилд орсон гадаадын зорчигчдын 72.5 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутгаас, 21.5 хувь нь Европоос, 4.3 хувь нь Америк тивээс, 1.7 хувь нь Ойрхи Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ (Зураг III.12).

Хилээр орсон гадаадын зорчигчдын 55.2 хувийг БНХАУ-ын иргэд, 13.8 хувийг ОХУ-ын иргэд, 7.6 хувийг БНСУ-ын иргэд, 3.2 хувийг АНУ-ын иргэд, 2.7 хувийг Япон улсын иргэд, 17.5 хувийг бусад орны иргэд эзэлж байна.

Энэ оны эхний хагас жилд манай улсын 766.9 мянган иргэн гадаадад зорчсоноос 642.3 мянга буюу 83.7 хувь нь хувийн журмаар зорчжээ.


Зураг-III.11

Монгол Улсын хилийн боомтуудаар нэвтэрсэн зорчигчид, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, мян.хүн



Зураг-III.12

Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчид, бүс нутгаар, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, хувиар



III.5 Аялал, жуулчлал

Хилээр нэвтэрсэн зорчигчид

Манай улсын хилээр 2013 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 1932.8 мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 118.7 мян.хүн буюу 5.8 хувиар буурчээ. Улсын хилээр 2013 оны эхний хагас жилд орсон зорчигчдын 48.8 хувь нь Замын-Үүд, 18.8 хувь нь Буянт-Ухаа, 9.2 хувь нь Алтанбулаг, 7.8 хувь нь Гашуун сухайт, 3.4 хувь нь Шивээ хүрэн, 12.0 хувь нь бусад боомтод ногдож байна.

Улсын хилээр энэ оны эхний хагас жилд гадаадын 217.3 мян.хүн орсон нь өмнөх оны мөн үеийнхээс 62.1 мянга буюу 22.2 хувиар буурчээ. Тэдний 90.2 хувь нь 30 хүртэл хоног, 3.3 хувь нь 90 хүртэл хоног, 6.5 хувь нь 90, түүнээс дээш хоногын хугацаагаар ирсэн байна. Гадаадын зорчигчдын 168.9 мянга нь буюу 77.7 хувь нь аялал жуулчлалын зорилгоор хилээр орсон нь өмнөх оны мөн үеийнхээс 15.1 хувиар буурсан байна. Хилээр орсон гадаадын зорчигчдын 47.0 мянга нь буюу 22.3 хувь нь ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоор иржээ. Өмнөх оны мөн үеийнхтэй



Улсын хилээр 2013 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 764.6 мянган тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 95.8 мянга буюу 11.1 хувиар буурсан бөгөөд эдгээрийн 37.4 хувийг ачааны машин, 30.5 хувийг ачааны вагон, 29.5 хувийг суудлын авто машин, 2.6 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна (Зураг III.13). Нийт тээврийн хэрэгслийн 89.1 хувь нь Замын-Үүд, Гашуун сухайт, Алтанбулаг, Шивээ хүрэн, Сүхбаатарын боомтоор нэвтэрсэн байна.

IV. Бусад

Цаг уур, агаарын бохирдол

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр хамгийн их хур тунадас 2013 оны 6 дугаар сард Дархан-Уул аймгийн Дархан суманд орж 125.0 мм-т хүрчээ. Энэ оны 6 дугаар сард Өмнөговь аймгийн Ханбогд суманд хамгийн их температур 37.5 хэм, Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ суманд хамгийн бага температур -6.4 хэм байлаа. Салхины хамгийн их хурд Говь-Алтай аймгийн Алтай, Хэнтий аймгийн Өндөрхаан суманд 28 м/с хүрчээ.

Аймгийн төв, нийслэлд агаарын дундаж хэм 2013 оны 6 дугаар сард олон жилийн дунджаас 0.2 хэм, өмнөх оны мөн үеийнхээс 0.8 хэмээр хүйтэн байлаа.


Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2013 оны 6 дугаар сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 30 удаа, Баруун дөрвөн замын орчимд 23 удаа, 32-ын тойрог орчимд 1 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн замын орчимд 18 удаа, Хархорин захын орчимд 14 удаа, 32-ын тойрог орчимд 10 удаа, 13-р хороолол орчимд 6 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 13-р хороолол орчимд 5 удаа, Баруун дөрвөн замын орчимд 2 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол 2013 оны эхний хагас жилд 2587 удаа гарсны улмаас 79 хүн амь насаа алдаж, 232.1 мян.толгой мал, амьтан хорогджээ. Энэ оны эхний хагас жилд объектын түймэр 2282 удаа, ой, хээрийн түймэр 124 удаа, мал, амьтны халдварт галзуу өвчин 44 удаа, гол, нуурын усанд хүн унасан осол 29


Зураг-III.13

Монгол Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, 2013 оны эхний хагас жилийн байдлаар, хувиар




Зураг-III.14

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, эхний 7 харуулын дундаж, сараар, (мг/м3)



Зураг-III.15

Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, эхний 7 харуулын дундаж, сараар, (мг/м3)





удаа, 3.5-аас дээш магнитудын газар хөдлөлт 27 удаа, хүчтэй салхи шуурга 23 удаа, аадар бороо, үерийн аюулт үзэгдэл 12 удаа, химийн хорт бодисын алдагдалтай холбоотой ослын дуудлага 11 удаа, бичил уурхайн нурангины осол, үхрийн хорт салст халуурал өвчин, сум галт хэрэгслийн осол тус бүр 7 удаа, аянгийн аюулт үзэгдэл, тэсэрч дэлбэрэх бодисын осол тус бүр 3 удаа, малын халдварт боом өвчин, үйлдвэрлэлийн осол тус бүр 2 удаа, зуд, малын халдварт маеди весна өвчин, малын гоц халдварт цэцэг өвчин, хоолны хордлого тус бүр 1 удаа бүртгэгджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас энэ оны эхний хагас жилд объектын түймэрт 6.8 тэрбум төг, ой, хээрийн түймэрт 3.0 тэрбум төг, хүчтэй салхи шуурганд 609.5 сая төг, мал, амьтны халдварт галзуу өвчинд 13.6 сая төг, малын халдварт боом, үхрийн хорт салт халуурал өвчин, тэсэрч дэлбэрэх бодисын осол, үйлдвэрлэлийн ослоор нийтдээ 8.6 сая төгрөгийн хохирол иргэн болон байгууллагад учирсан байна. Объектын түймрээр 38 хүн, гол нуурын усанд унасан ослоор 30 хүн, бичил уурхайн нурангины ослоор 6 хүн, ой, хээрийн түймрээр 2 хүн, аадар бороо үерийн аюулт үзэгдэл, хүчтэй салхи шуурга, үйлдвэрлэлийн ослоор тус бүр 1 хүн амь насаа алджээ.

Өмнөх оны мөн үеийнхээс аюулт үзэгдэл, ослын тохиолдол 265-аар нэмэгдэв.

Хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтдын тоо 2013 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеийнхээс 224.8 мян.толгойгоор их байна (Хүснэгт III.5).

Хүснэгт-III.5

Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар*

Үзүүлэлт	2011 I-IV	2012 I-IV	2013 I-IV	2013 I-IV, %	
				2012 I-IV	%
Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо	1 900	2 322	2 587		111.4
Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо	113	104	79		76.0
Шатсан гэр, орон сууцны тоо	838	1 244	1 146		92.1
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтан, толгой	165 113	7 279	232 116		3 188.8
Объектын түймрийн тоо	1 621	2 056	2 282		111.0
Учирсан хохирлын хэмжээ, тэрбум төг	2.7	13.9	10.4		74.6

*-Онцгой байдлын ерөнхий газрын мэдээ

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

С.МЭНДСАЙХАН

2013 оны 7 дугаар сарын 10

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхнэр хагас жилийн байдлаар бүс аймаг, нийслэлээр

